

ТӨВ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Аудит хийх үндэслэл: Үндэсний аудитын газрын 2014 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон бүрэн эрхийн дагуу хийв.

Аудитын ерөнхий дүгнэлт:

Аймгийн Засаг дарга эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар хуулинд заагдсан бүрэн эрхээ хэрэгжүүлж ажилласан боловч Эрүүл мэндийн сайдтай байгуулсан гэрээгээ дүгнээгүй, Эрүүл мэндийн газрын даргатай үр дүнгийн гэрээ байгуулаагүй ажилласан байна.

Аудитын нэр:

Эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилт, эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, оношилгооны тоног төхөөрөмжийн худалдан авалт, ашиглалт, зарцуулалт



Зуунмод
2014 он

АГУУЛГА

Аудитын тайланг бэлтгэсэн: ҮАГ-ын харьяа Төв аймгийн Аудитын газар Дарга, тэргүүлэх аудитор Л.Жаргалсайхан Аудитын менежер О.Амаржаргал Аудитор Д.Пүрэвсүрэн Шинжээч Ч.Загдсүрэн 2014 оны 04 дугаар сарын 04 Уг тайланг АГ-ын Веб сайт-аас үзнэ үү. http://tuv-audit.mn/ Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70273463 дугаарын утас, 22582 дугаарын факсаар харилцана уу. ХАЯГ: Төв аймгийн Төрийн байгууллагын ордон	Товчилсон үгийн тайлбар.....4 Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт.....5 Үндсэн зорилт: Эрүүл мэндийн тухай хууль хэрэгжиж байна уу? БҮЛЭГ -1 Эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлж байна.....7-13 Дүгнэлт 1.1 Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэргүүлэх чиглэл болгож эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлэхэд эрүүл мэндийн байгууллагын бие даасан нээлттэй, өмчийн олон хэлбэрт тулгуурласан байдлыг ханган ажиллаж байна. Дүгнэлт 1.2 Хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг ялгаварлан гадуурхахгүйгээр тэгш, хүртээмжтэй үзүүлж байна. Дүгнэлт 1.3 ЭМ-ийн бодлого, арга хэмжээг Төрийн болон ТББ, аж ахуйн нэгж байгууллага, хамт олон гэр бүл иргэний нэгдмэл үйл ажиллагаагаар хэрэгжүүлж байна. Дүгнэлт 1.4 Орчин үеийн болон уламжлалт анагаах ухааны дэвшилтэд аргад тулгуурлан хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж байна. БҮЛЭГ- 2 Төв орон нутгийн төрийн байгууллагууд “Эрүүл мэндийн тухай” хуулинд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлж байна. Дүгнэлт 2.1 Үндэсний аудитын газраас дүгнэлт гарах Дүгнэлт 2.2 Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар бүрэн эрхээ хэрэгжүүлэн ажиллаж байна. Дүгнэлт 2.3 Аймгийн Засаг дарга эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар хуулинд заагдсан бүрэн эрхээ хэрэгжүүлж ажилласан боловч Эрүүл мэндийн газрын даргатай үр дүнгийн гэрээ байгуулаагүй ажилласан байна. Дүгнэлт 2.4 Аймгийн хэмжээнд 5 суманд их эмчийн стандарт хангалт дутагдалтай, сумдад эмнэлгийн дунд мэргэжилтэн бага эмч, сувилагчийн хангалт 89.4 хувьтай байна. БҮЛЭГ- 3 Эрүүл мэндийн байгууллагын тогтолцоо зөв байна.....14-26 Дүгнэлт 3.1 Аймгийн эрүүл мэндийн салбарын зүгээс нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр тусламж, үйлчилгээг хангалттай үзүүлж байна. Дүгнэлт 3.2 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанрын шалгуур үзүүлэлт өнгөрсөн оноос сайжирч, аймгуудын чанрын дундаж үзүүлэлтээс дээгүүр байна. Дүгнэлт 3.3 Төсөв мөнгөний хүрэлцээгүй байдлаас болж эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдээр эм, тариа авахуулах тохиолдол зарим үед гардаг байна.
---	---

БҮЛЭГ- 4 Эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцоог өөрчлөх шаардлагатай байна.

Дүгнэлт 4.1 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилт нь хүн амын эрүүл мэндийг сайжруулах, хүн амд тэгш хүртээмжтэй, чанартай тусламж, үйлчилгээ үзүүлэхэд хүрэлцдэггүй байна.

БҮЛЭГ- 5 Эрүүл мэндийн эмчилгээ, үйлчилгээнд тавих хяналт зохих түвшинд явагдаж байна.

Дүгнэлт 5.1 Чанарын хяналтыг эрүүл мэндийн байгууллагын дотоод хяналтын багаар болон Мэргэжлийн хяналтын газрын шалгалтаар хийж илэрсэн алдаа, зөрчлийг арилгуулах арга зүйн зөвлөмж өгч хэрэгжүүлэн ажилладаг байна.

2013 оны Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаа оновчтой хэрэгжүүлсэн үү?

БҮЛЭГ -1 Эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтийн хэрэгжилт хангагдсан байна

Дүгнэлт 1.1 Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт эрүүл мэндийн салбарт 2013 онд хэрэгжүүлэхээр тусгасан нэг зорилт хэрэгжих хугацаа болоогүй байна.

Дүгнэлт 1.2 Эрүүл мэндийн сайд аймгийн Засаг даргын хооронд байгуулсан Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөл хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээгээ дүгнээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 40.3 дахь заалтыг зөрчсөн байна.

Дүгнэлт 1.3 Эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтийн хэрэгжилт хангагдсан байна.

Улсын төсвийн хөрөнгөөр 2013 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байна уу?

БҮЛЭГ -А Хөрөнгө оруулалтын эх үүсвэр нь зураг төсвийн дагуу батлагддаггүй байна.....

Дүгнэлт А.1 Аймгийн ИТХ-аас 2009 онд батласан төлөвлөгөөний дагуу хөрөнгө оруулалт, их засварын ажлууд хийгдэж байна.

Дүгнэлт А.2 Барилгын засвар, хөрөнгө оруулалтын ажлын хөрөнгийн эх үүсвэр нь зураг, төсвийн дагуу батлагддаггүй байна.

БҮЛЭГ–Б Худалдан авах ажиллагааг ТБОНӨХБАҮХАТухай хуулийн дагуу явуулаагүй байна.....

Дүгнэлт Б.1 Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах ажиллагаа нь ТБОНӨХБАҮХАТухай хуулийг зөрчжээ.

	Дүгнэлт Б.2 Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа хугацаа алдаж зохион байгуулагдснаас 100,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийгдээгүй байна. БҮЛЭГ -В ЭМЯ-наас хийгдэж байгаа хөрөнгө оруулалт үр дүн хангалтгүй байна. Дүгнэлт В.1 Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд хариуцлагын асуудал бүрэн тусгагдаагүй байна. Дүгнэлт В.2 Ашиглагч байгууллагын төлөөлөлийг оролцуулан ажил хүлээлцэх комисс ажиллуулсан байна. Дүгнэлт В.3 2006 онд буцаан татаж авсан хөрөнгө дансанд бүртгэлтэй байна. Дүгнэлт.....27 Зөвлөмж.....28 Холбогдох байгууллагын санал: <table><tr><td>Холбогдох</td><td>байгууллагаас</td><td>ирүүлсэн</td><td>санал</td></tr><tr><td colspan="4">.....</td></tr></table>	Холбогдох	байгууллагаас	ирүүлсэн	санал				
Холбогдох	байгууллагаас	ирүүлсэн	санал						
.....									

Товчилсон үгийн тайлбар

ҮАГ	Үндэсний аудитын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ТБОНӨХБҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ЭМС	Эрүүл мэндийн салбар
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
МУ	Монгол улс
УИХ	Улсын их хурал
ЭМБ	Эрүүл мэндийн байгууллага
ЭМ	Эрүүл мэнд
ТББ	Төрийн бус байгууллага
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын зорилт: “Эрүүл мэндийн тухай хууль”-ийн хэрэгжилт, эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, оношилгооны тоног төхөөрөмжийн худалдан авалт, ашиглалт, зарцуулалтад аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- “Эрүүл мэндийн тухай хууль”-ийн хэрэгжилт
- Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн
- Эрүүл мэндийн салбарын багцын 2013 оны хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа, үр дүн
- 2013 онд оношилгооны тоног төхөөрөмжийн худалдан авалт, ашиглалт, зарцуулалт оновчтой эсэх

Аудитын хамрах хүрээ: Аудитаар ЭМЯ-ны 2013 оны үйл ажиллагаа, ЭМС-ын нийслэл, аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилт, түүний эрх зүйн байдал, улсын төсвийн хөрөнгө оруулалт болон бүх төрлийн хөрөнгийн эх үүсвэрээр нийлүүлсэн оношилгооны тоног төхөөрөмжийн худалдан авалт, ашиглалт, зарцуулалтыг ЭМЯ, түүний

харьяа бүх шатны эмнэлэг, Цөмийн энергийн газар, МХЕГазар болон аймаг орон нутагт эрх шилжсэн хөрөнгийн хүрээнд шалгалаа.

Аудитын арга зүй: Аудитын явцад холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийж, асуулга лавлагаа болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглахаас гадна Төрийн хяналт, шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын гарын авлагад дурдсан аудитын арга зүйг мөрдөж, аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараахь хууль, тогтоомжийг шалгуур үзүүлэлт болгов.

- МУ-ын 2013 оны төсвийн тухай хууль болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт

- Төсвийн тухай хууль
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- ТБОНӨХБҮХАТухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Гадаадын зээл тусламжийг зохицуулах тухай хууль
- Дээрх хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гаргасан УИХ, ЗГ-ын тогтоол, бусад эрхийн актууд
- Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын журам”
- Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”

Аудитын хугацаа, тайланд тусгагдах мэдээлэл: Аудитыг 2014 оны 02 дугаар сарын 03-нд эхэлж, 2014 оны 04 дүгээр сарын 25-нд дуусгаж, Аудитын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, 2014 оны 05 дугаар сарын 01-нд УИХ-д хүргүүлнэ.

Аудитын тайланд дэвшүүлсэн зорилт, хамарсан хүрээ, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж, хавсралт судалгаанаас гадна холбогдох байгууллагын саналыг тусгалаа.

Аудит хийх бүрэлдэхүүн: Аудитыг аймгийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал удирдан, аудитор Д.Пүрэвсүрэн, шинжээч Ч.Загдсүрэн нар 2014 оны 03-р сарын 01-нээс 04-р сарын 01-нийг хүртэл хийж гүйцэтгэв.

Эрүүл мэндийн тухай хууль хэрэгжиж байна уу?

2013 онд Эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлж байна уу?

Бүлэг 1

Эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлж байна.

1.1. “Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэргүүлэх чиглэл болгож” улмаар эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлэхэд Эрүүл мэндийн байгууллагын бие даасан, нээлттэй, өмчийн олон хэлбэрт тулгуурласан байдлыг ханган ажиллаж чадаж байна уу?

Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэргүүлэх чиглэл болгож эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлэхэд эрүүл мэндийн байгууллагын бие даасан нээлттэй, өмчийн олон хэлбэрт тулгуурласан байдлыг ханган ажиллаж байна.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэргүүлэх чиглэлээ болгох зорилтын хүрээнд 2012-2016 онд “Нийгмийн эрүүл мэндийн талаар аймгаас баримтлах бодлого”-ыг 6 зорилт, 28 хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөтэй шинэчлэн боловсруулж, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн 2012 оны 76 тоот тогтоолоор батлуулсан. “Нийгмийн эрүүл мэндийн талаар аймгаас баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний эхний 1 жилийн хэрэгжилтийг 2013 онд аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлэн, бодлогын хэрэгжилтийг цаашид хэрхэн хангаж ажиллах талаар санал зөвлөмж авч, өссөн дүнгээрээ 22.75%-тай дүгнэгдсэн байна. ИТХ-аас Нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээг дэмжих зорилгоор ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2012 оны “Нийгмийн эрүүл мэндийн өдөр бий болгох тухай” 100 дугаар тогтоолоор 7 хоног бүрийн 3 дахь өдрийг Нийгмийн эрүүл мэндийн өдөр болгосон. Уг тогтоолыг хэрэгжүүлэхээр аймгийн Засаг даргын 2012 оны 551 тоот захирамжаар “Нийгмийн эрүүл мэндийн өдөр” иргэдийн дунд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл аж төрөх зан үйлд суралцуулах, дасгал хөдөлгөөн, нийтийн биеийн тамираар хичээллүүлэх, эрүүл мэндээ хамгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх төрөл бүрийн арга хэмжээ, уралдаан тэмцээнийг төлөвлөгөөтэйгөөр өргөн хүрээтэй зохион байгуулж ажиллах талаар сумын Засаг дарга, байгууллагуудын дарга нарт үүрэг чиглэл өгч, 20 заалт бүхий хэрэгжүүлэх арга хэмжээ, байгууллагын төлөвлөгөөнд холбогдох заалтуудыг тус тус оруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 6 дугаар бүлгийн Нийгмийн хөгжлийн бодлогын 28 дугаар зорилтод “Халдварт бус өвчин, халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх үйл ажиллагааг сайжруулан, өвчлөлийг бууруулна”, 29 дүгээр зорилтот “Эрүүл аймаг, сум, баг, ажлын байр, сургууль бий болгох хөтөлбөрийг хэрэгжүүлэх” гэсэн зорилтуудыг дэвшүүлэн, 5 арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлж байна. Мөн Төв аймгийн Эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 5 дугаар бүлгийн Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд

“Нийгмийн эрүүл мэндийн талаар аймгаас баримтлах бодлогыг хэрэгжүүлэн, халдварт болон халдварт бус өвчний илрүүлгийн үзлэгийг сайжруулна” хэмээн 37 дугаар зорилтыг дэвшүүлэн, хэрэгжилтийг зохион байгуулж, тайланг хагас, бүтэн жилээр Хяналт-шалгалт, үнэлгээ, дотоод аудитын албанд тайлагнан, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэн ажиллаж байна. 2013 оны жилийн эцсийн байдлаар аймгийн Засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан эрүүл мэндийн салбарын нийт 6 зорилтын 27 арга хэмжээ тайлант оны гүйцэтгэлээрээ 96.81%-тай, Төв аймгийн Эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан 4 зорилт, 18 хэрэгжүүлэх арга хэмжээ 95.0%-ийн гүйцэтгэлтэй дүгнэгдсэн байна.

2013 онд аймгийн хэмжээнд хэрэгжиж буй нийгмийн эрүүл мэндийн үндэсний болон аймгийн 12 дэд хөтөлбөр, 8 стратегүүдийн тайланг 88.6-89.49 хувийн хэрэгжилттэй, Эрүүл мэндийн сайдын 2013 оны 448 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын дагуу аймгийн Нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн Эрүүл мэндийн төвөөс авч нэгтгэн **аймгийн** Засаг даргын тамгын газар, Эрүүл мэндийн яаманд хүргүүлэн ажиллаж байна.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхээр эрүүл мэндийн байгууллагуудад Нийгмийн эрүүл мэндийн ажилтан ажилласнаар гэр бүл төлөвлөлт, эмэгтэйчүүд эсэн мэнд амаржихуй, нөхөн үржихүйн эрүүл мэнд, хүүхэд өсвөр үеийн эрүүл мэнд, халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл зөв хооллолт, эрүүл мэндийг дэмжих, орчны эрүүл мэнд, хүн амын бие бялдрын чийрэгжүүлэлт, эрүүл мэндийн боловсрол, зан үйлийн төлөвшилтэй холбоотой эрүүл мэндийн арга хэмжээг хувь хүн, гэр бүл, хамт олонд хүртээмжтэй, энгийн арга хэлбэрээр, өөрсдийг нь оролцуулах замаар зохион



байгуулдаг болсон байна.

Улсын их хурлын 2001 оны 81 дүгээр тогтоолоор батлагдсан “Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого”-ын 4 дүгээр бүлгийн 4.1.1 заалтын дагуу өмчийн аль ч хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг дэмжих замаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг иргэдэд чанар, хүртээмжтэй үзүүлж байна. Аймгийн хэмжээнд төрийн хэвшлийн анхан шатны сумын Эрүүл мэндийн төв 26, өрхийн Эрүүл мэндийн төв 2, хоёрдогч шатлалын аймгийн Нэгдсэн эмнэлэг 1, хувийн хэвшлийн эмнэлэг 12, рашаан сувилал 9, эмийн сан 10, бусад 2 байгууллага, нийт 62 байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

Төр хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын харьцаа (хувиар)



Эдгээр байгууллагад 2013 оны эцсийн байдлаар 1223 хүн ажиллаж байгаагийн бүрэлдэхүүнээр авч үзвэл удирдах ажилтан 6, их эмч 180, эм зүйч 14, бага эмч 82, сувилагч 258, эх баригч 27, лаборант 32, эм найруулагч 34, нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн 23, статистикч бага эмч 30 бусад ажилтан 537 хүн тус тус ажиллаж байна. Аймгийн хэмжээнд төрийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад жилдээ нийт 10786.4 сая төгрөгийн төсвийн хөрөнгийг зарцуулж байна. Үүнийг тодруулбал аймгийн Эрүүл мэндийн газар 1202.3 сая төгрөг, аймгийн Нэгдсэн эмнэлэг 3997.8 сая төгрөг, сумын болон өрхийн анхан шатны эмнэлэг 5586.3 сая төгрөгийн төсвийг тус тус зарцуулж байна.

Эрүүл мэндийн тухай хуулийн 4 дүгээр бүлгийн 19.4 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2013 оны 145 дугаар тушаал батлагдсан “Эрүүл мэндийн чиглэлээр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичигт тавигдах шаардлага”, Эрүүл мэндийн сайдын 2013 оны 143 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын ажиллах удирдамж”-ийн дагуу зориулалтын барилга байгууламж, техник хэрэгсэл,

боловсон хүчин бүхий өмчийн аль ч хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагад эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай **зөвшөөрөл** олгож байна. Аймгийн хэмжээнд тусгай зөвшөөрөлтэй 49 байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас эмийн сан 21, ортой эмнэлэг 4, үүдэн эмнэлэг 10, сувилал 14 тус тус ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд эрүүл мэндийн салбарын хувьд Эрүүл мэндийн тухай хуулиар хүлээсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтийн шалгуурыг хангаж ажиллан, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэргүүлэх чиглэл болгож эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлэхэд эрүүл мэндийн байгууллагын бие даасан нээлттэй, өмчийн олон хэлбэрт тулгуурласан байдлыг ханган ажиллаж байна.

1.2. Хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг ялгаварлан гадуурхахгүйгээр тэгш, хүртээмжтэй үзүүлж чадаж байна уу?

Хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг ялгаварлан гадуурхахгүйгээр тэгш, хүртээмжтэй үзүүлж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 2 дугаар бүлгийн 16.6 “Монгол улсын иргэн эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй” гэсэн заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 1 дүгээр бүлгийн 4.1.2. “Хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг ялгаварлан гадуурхахгүйгээр тэгш хүртээмжтэй үзүүлэх” заалтуудыг бүрэн хэрэгжүүлж, хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг ялгаварлан гадуурхахгүйгээр тэгш, хүртээмжтэй үзүүлж байна.

1.3 ЭМ-ийн бодлого, арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллага, нутгийн захиргааны болон орон нутгийн өөрөө удирдах байгууллага, аж, ахуйн нэгж байгууллага, хамт олон, гэр бүл, иргэний нэгдмэл үйл ажиллагаагаар хэрэгжүүлж чадаж байна уу?

ЭМ-ийн бодлого, арга хэмжээг Төрийн болон ТББ, аж ахуйн нэгж байгууллага, хамт олон гэр бүл иргэний нэгдмэл үйл ажиллагаагаар хэрэгжүүлж байна.

Эрүүл мэндийн тухай хуулийн 4.2.3-ын “Эрүүл мэндийн бодлого, арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллага, нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, хамт олон, гэр бүл иргэний нэгдмэл үйл ажиллагаагаар хэрэгжүүлэх” гэсэн заалт, Монгол Улсын Их Хурлын 2001 оны 81 дүгээр тогтоолоор батлагдсан “Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого”-ын 2.1.5-ын “Нийгмийн эрүүл мэндийн асуудлаар салбар хоорондын үйл ажиллагааг зохицуулж, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүн гэр бүл, хамт олны оролцоонд тулгуурлан түншлэлийг хөгжүүлэх” гэсэн заалтын хүрээнд Эрүүл мэндийн сайдын 2013 оны 74 тушаалаар жил бүрийн 3 дугаар сарын 18-ны өдрийг “Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн дэмжих өдөр” болгон зарласантай холбогдуулан Зуунмод сумын Засаг даргын Тамгын газар, орон нутгийн ТББ телевизтэй хамтран “Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн дэмжих өдөр”-ийг “Эрчүүдээ хайрлая” уриан дор нээлттэй өдөрлөг зохион байгуулж, эрүүл **аж** төрөх зан үйлийг төлөвшүүлэх чиглэлээр иргэдэд эрэгтэйчүүдэд сургалт сурталчилгааны материал тарааж, эрчүүдийн эрүүл мэндийн талаар зөвлөгөө нэвтрүүлэг хийж, биеийн жингийн индексийг тодорхойлж, артерийн даралтыг нь үзэж заавар зөвлөгөө өгч, байгууллагуудын эрэгтэй ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулав.

Эрүүл мэндийн яам, Нийгмийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв, Монголын Мянганы Сорилтын Сангийн Эрүүл Мэнд Төсөл, ЭПОС зөвлөх байгууллагатай хамтран “Салбар хоорондын зохицуулалт ба манлайлал-нийгмийн эрүүл мэндийн асуудал” семинарыг

зохион байгуулж, аймгийн Нийгмийн эрүүл мэндийн салбар Зөвлөлийн гишүүд, Эрүүл мэндийн газрын эмч, мэргэжилтнүүдийг оролцуулсан байна.

Дэлхийн зөн олон улсын байгууллагын хөтөлбөрийн зохицуулагч, Сувиллын цэцэрлэг яслийн 10 дугаар цогцолборын Нийгмийн эрүүл мэндийн ажилтан, эмч, хөдөлгөөн засалч нартай хамтран Борнуур, Угтаалцайдам сумын Эрүүл мэндийн төвд “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ” сэдэвт бүсчилсэн үзүүлэх сургалтыг сумын эрүүл мэндийн төвийн эмч, сувилагч, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, тэдгээрийн эцэг эх асран халамжлагч нарыг хамруулан зохион байгуулжээ.

Эрүүл мэндийн сайдын 2010 оны “Төсөл дэмжих баг байгуулах тухай” 16/2279 тоот албан бичиг, аймгийн ЗДТГ-ын 2010 оны 321 дугаар захирамжаар Эрүүл мэндийн яам, Нийгмийн Эрүүл мэндийн үндэсний Төв, Азийн Хөгжлийн Банкны “Бага насны хүүхдийн хоол тэжээлийн архаг дутлыг бууруулах JFPR 9131” төслийн багтай хамтран “Төв аймгийн Батсүмбэр, Эрдэнэ, Баянцогт, Зуунмод, Лүн сумдын 06-23 сартай хүүхдийн бичил тэжээлийн холимогийн хэрэглээг нэмэгдүүлж, хооллох дадлыг сайжруулах” 22.0 мянган ам долларын санхүүжилтэй төслийг хэрэгжүүлж, 5 сумын нийт 1450 хүүхдийг хамруулан, сайн дурын 50 ажилтнуудыг бэлтгэж, Олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэлийн талаар



мэдлэг олгож сурталчилгаа хийж зөвлөгөө өгөх чадвартай болгон, 06-23 сартай хүүхдүүдийн 12% цус багадалттай, 5.4% тураалтай, 16.2% өсөлт хоцролттой, 1.2% нь туранхай, 32.4% нь рахиттай гэсэн суурь судалгаа гарч, төсөл хэрэгжсэний үр дүнд цус багадалтыг 22%-иар, рахитыг 30%-иар тус тус бууруулж чадсан байна.

“Шинэ нийгмийн эрүүл мэнд” төрийн бус байгууллагатай хамтран Азийн Хөгжлийн Банкны дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Бага насны хүүхдийн хоол тэжээлийн архаг дутлыг бууруулах нь” JFPR 9131 төслийн хүрээнд “Ирээдүй цогцолбор” цэцэрлэгт үзүүлэх **сургалт** зохион

байгуулсан байна.

Дэлхийн Зөн олон улсын байгууллага, “Гал голомт” хөтөлбөр, “Бага насны хүүхдийн хоол тэжээлийн архаг дутлыг бууруулах нь”, Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрсдэлт хүчин зүйлийг бууруулах, хөдөлгөөн, хоол, архи, тамхины хор хөнөөл, “Бага насны хүүхдийн хоол”, “Эх нялхсын эрүүл мэндийг хамгаалах тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах нь” бүсчилсэн өдөрлөгийг 6 суманд 6 удаа нийт 440 эмч, эмнэлгийн ажилчин болон иргэдийг хамруулан зохион байгуулсан. Дэлхийн Зөн олон улсын байгууллага, Цагдаагийн газар, Зуунмод сумын Засаг даргын Тамгын газартай хамтран “Нийгэмд таны оролцоо” сургалт, зөвлөгөөн зохион байгуулж, архины хамааралтай 60 хүнийг хамруулсан байна. Мөн аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн ажлын хэсэгтэй хамтран Баян, Баянцагаан, Эрдэнэсант, Цээл сумдад “Архинд донтох өвчин” сэдвээр бүсчилэн өдөрлөг зохион байгуулж, нийт 850 гаруй иргэдэд мэдээлэл хийсэн байна. Эрүүл мэндийн болон бусад салбарт Архи, тамхигүй ажлын байр бий болгох замаар эрүүл зан үйл төлөвшүүлэх, ажиллах орчин бүрдүүлэх, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд байгууллага, хамт олны оролцоо, манлайллыг нэмэгдүүлэх зорилгоор Эрүүл мэндийн газар, Зуунмод сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл, Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллагын Төв орон нутгийн хөгжлийн хөтөлбөр хамтран “Ажлын байрны эрүүл хэвшилд нэгдэцгээе” 2 сарын аян зохион байгуулж, 22 удаа сургалт, хэлэлцүүлэг явуулж, нийт 45 байгууллагын 810 ажилтныг хамруулсан. “Ажлын байрны эрүүл хэвшилд нэгдэцгээе” уралдааны болзол гарган дүгнэхэд Цагдаагийн газар, Төв чандмань Дулааны эрчим хүчний газар, Тагнуулын газар зэрэг байгууллагууд шалгарсан байна.

“Эрүүл мэндийг дэмжигч байгууллага” шалгаруулах Эрүүл мэндийн сайдын 184 дүгээр тушаал, Нийгмийн хөгжлийн хэлтсийн даргаар шинэчлэн батлуулсан “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага шалгаруулах болзол”, журмыг 27 сумын Засаг даргад хүргүүлж, арга зүйн зөвлөмж өгч ажилласнаар 7 сумын 15 байгууллага “Эрүүл мэндийг

дэмжигч байгууллага” болох зорилт тавин **ажиллах** хүсэлтээ ажлын хэсэгт ирүүлснээс 2013 онд 10 байгууллагыг шалгаруулан, 1-3 дугаар зэргийн гэрчилгээ олгосон. 2012 онд 5 байгууллагыг шалгаруулан урамшуулсан, нийт 15 эрүүл мэндийг дэмжигч байгууллагатай болсон.

Эрүүл мэндийн бодлого, арга хэмжээг Төрийн болон ТББ, аж ахуйн нэгж байгууллага, хамт олон гэр бүл иргэний нэгдмэл үйл ажиллагаагаар хэрэгжүүлж байна

1.4 Орчин үеийн болон уламжлалт анагаах ухааны дэвшилтэд аргад тулгуурлан хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж чадаж байна уу?

Орчин үеийн болон уламжлалт анагаах ухааны дэвшилтэд аргад тулгуурлан хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж байна.

Орчин үеийн болон уламжлалт анагаах ухааны дэвшилтэд аргад тулгуурлан хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх ажлын хүрээнд Эрүүл мэндийн салбарт мэдээллийн технологи, алсын зайн оношлогооны эмчилгээг нэвтрүүлэх талаар гаргасан Эрүүл мэндийн сайдын 2009 оны “Эрүүл мэндийн цахим мэдээллийн нууцлал, аюулгүй байдлын журам батлах тухай” 357 тоот тушаал, 2009 оны “Цахим эрүүл мэндийн стратеги” 450 тоот тушаал, 2010 оны “Телемедициний үндэсний сүлжээ байгуулах тухай” 372 тоот тушаал, 2011 оны 87 тоот тушаал “Эрүүл мэндийн удирдлагын мэдээллийн тогтолцоог хөгжүүлэх стратеги”, 2012 оны “Телемедицинийг оношилгоо, эмчилгээ, зөвлөгөө авахад ашиглах тухай” 392 тоот тушаал, 2012 оны “Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 375 тоот тушаалын 6-р заалт болон Аймгийн Засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Төв аймгийн эрүүл мэндийн салбарын хөгжлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөө /2011-2015/-ний дагуу Эрүүл мэндийн газрын даргын 2012 оны а/147 тоот тушаалаар аймгийн Нэгдсэн эмнэлгийн алсын зайн оношилгооны хэсэгт зориулалтын тоног төхөөрөмжийг хуваарилан ашиглаж байна.

2012 онд аймгийн Нэгдсэн эмнэлгийн алсын зайн оношилгооны хэсэгт “Эрүүл Мэндийн Салбарын Хөгжил Хөтөлбөр-3” төслийн 29.2 сая төгрөгийн санхүүжилтээр зайнаас оношлох, зөвлөгөө авах, эмчлэх үйлчилгээг үзүүлэхэд зориулагдсан видео, аудио иж бүрдэл, телевизор, скайнер, компьютер, нийлүүлсэнээр аймгийн Нэгдсэн эмнэлгийн бүх тасаг, нэгжүүд эмнэлзүй, эмгэг судлалын оношлогоо, зөвлөгөө, сургалтыг зайнаас авах боломжтой болжээ. **Аймгийн** Нэгдсэн эмнэлгийн телемедицинээр 2012 онд зайн сургалт-15, теле уулзалт-4, зайн зөвлөгөө-6 хийгдсэн бол 2013 онд зайн сургалтанд 12 удаа нийт 144 эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүд хамрагдаж, зайн уулзалт ярилцлага 9 удаа, зайн зөвлөгөө 2 удаа авч ажилласан байна.

Мөн 2013 онд аймгийн Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасагт НҮБ-ын Хүүхдийн сангийн төслийн хүрээнд телемедициний зориулалтаар иж бүрэн dell компьютер, notebook, зурагт, дүрс дамжуулагч болон бусад хэрэгслүүдийн хамт хүлээн авч суурилуулав. Төслийн үр дүнд Эх Хүүхдийн Эрүүл Мэндийн Үндэсний Төвийн сэхээн амьдруулах, эрчимт эмчилгээний тасагтай шууд холбогдож эмчилгээ, оношилгооны хамтарсан зөвлөгөө хийж, эмч мэргэжилтнүүд чадавхижих боломжоор хангагдаж орчин үеийн дэвшилтэд технологийг нэвтрүүлэн ажиллаж байна.

Эмчилгээ оношилгооны удирдамж, стандарт байнга шинэчлэгдэн батлагдаж ирсний дагуу сүүлийн 3 жилд дараах удирдамжууд шинэчлэгдэн хэрэгжиж эхлээд байна.

Үүнд: Насанд хүрэгсэдийн артерийн гипертензи, Чихрийн шижин хэвшинж II өвчний оношлогоо эмчилгээ, Хөх, умайн хүзүүний өмөнг эрт илрүүлэх, Олон нийтэд түшиглэсэн хүүхдийн өвчний цогц менежмент, Жирэмслэлт төрлөгийн хүндэрлийг удирдах арга зүй, Сэтгэцийн өвчний үеийн сувилахуйн тусламж үйлчилгээ, өдрөөр үзүүлэх сувилахуйн тусламж үйлчилгээ, Гамшиг осол, байгалийн гэнэтийн аюулын үед үзүүлэх сувилахуйн тусламж үйлчилгээ зэрэг 8 удирдамжуудыг хэрэгжүүлэх арга хэмжээг авч ажиллаж байна.

Чихрийн шижин хэв шинж II, артерийн гипертензи, хөх, умайн хүзүүний өмөн эрт илрүүлэх удирдамжийг хэрэгжүүлэхээр орон даяар Монголын Мянганы Сорилтын Сангийн Эрүүл Мэнд Төслийн төслөөр эмч мэргэжилтнүүдийн 92 хувийг сургалтанд хамруулан, багаж тоног төхөөрөмжөөр хангасан байна. 2012 оноос өрх, сумдын эмч нар эрт илрүүлгийн үзлэг зохион байгуулсан байна. 2013 онд Чихрийн шижин хэвшинж II- ийн эрт илрүүлгийн хамрагдалт-38.38 хувь, артерийн гипертензи-43.96 хувь, хөхний өмөн, умайн хүзүүний өмөнг эрт илрүүлэлт -63.97 хувьтай байна. Үзлэгийн мэдээг сар тутмын мэдээллийн номонд сум бүрээр гарган, хамрагдалтыг нэмэгдүүлэх ажил зохион байгуулж, эргэн мэдээлэл хийж байна.

Олон нийтэд түшиглэсэн хүүхдийн өвчний цогц менежментийн дагуу өрх сумдын эмч, эмнэлгийн ажилчдын 85%-ийг хамруулсан сургалт зохион байгуулсан байна. 2013 онд 10 сумын, 2 өрхийн эрүүл мэндийн төвийн, 2014 онд 3 сумын эрүүл мэндийн төвийн 92 эмч, сувилагч буюу 72.9% нь тандалтад хамрагдсан “Бага насны хүүхдийн архаг дутлыг бууруулах нь GFPR 9131” төслийн судалгаанд манай аймаг хамрагдан төсөл амжилттай хэрэгжсэн гэсэн үнэлгээ авсан. Амилуулах суурь тусламжаар сургагдсан багш нар орон нутагт сургалт зохион байгуулж байгаа бөгөөд манай аймагт 1-р эмнэлгийн сэхээний эмч сургалт зохион байгуулж, 28 эмч хамрагдсан. Дээрх удирдамж хэрэгжүүлсний үр дүнд эрүүл мэндийн статистик үзүүлэлт болох тухайн өвчний өвчлөл нас баралтаар 5-6 жилийн дараа гарах юм байна.

“Монголын уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого”-ын хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн сайдын 2010 оны 386 дугаар тушаалаар батлагдсан “Монголын уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх хөтөлбөр” батлагдсаны дагуу аймаг орон нутгийн онцлогт тохируулан 4 зорилт 15 шалгуур үзүүлэлтэйгээр боловсруулж хэрэгжилтийг 2013 оны эцсийн байдлаар 75 хувиар ханган ажиллаж байна. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт Уламжлалт эмчилгээний кабинет 1996 оноос 10 гаруй төрлийн эмчилгээ хийгдэн эхэлж, өнөөгийн байдлаар Уламжлалт анагаах ухааны хэвтэн эмчлүүлэх тасаг болон өргөжиж 13 ортой, их эмч 1, ахлах сувилагч 1, ээлжийн сувилагч 3 зэрэг 10 ажиллагсадтай тасаг хэвийн үйл ажиллагаа явуулж байна.

Уламжлалт сэргээн засах эмчилгээний чанарыг сайжруулан эмийн бус эмчилгээний нэр төрөл хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Аргалант, Сэргэлэн, Баянцогт, Алтанбулаг, Эрдэнэ, Эрдэнэсант, Баянцагаан, Мөнгөнморьт, Цээл, Лүн сумын эрүүл мэндийн төвүүдэд уламжлалтын эмч нар ажиллан, Манба Дацан эмийн үйлдвэр, Монг-эм, Уламжлалт Анагаах Ухааны корпорациас тус тус 12-70 төрлийн эм татан авч эмчилгээ, үйлчилгээнд хэрэглэж байна.

Орчин үеийн болон уламжлалт анагаах ухааны дэвшилтэд аргад тулгуурлан хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж байна.

Эрүүл мэндийн салбарын төв, орон нутгийн байгууллагын удирдлага бүрэн эрхээ хэрэгжүүлж чадаж байна уу?

Бүлэг 2

Төв орон нутгийн төрийн байгууллагууд “Эрүүл мэндийн тухай” хуулинд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлж байна.

2.1. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бүрэн эрхээ хэрэгжүүлж чадаж байна уу?

Үндэсний аудитын газраас дүгнэлт гарах

Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн “Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх”-ийн хүрээнд:

8.1.4. Хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг салбарын хэмжээнд төлөвлөх, зохион байгуулах, эрүүл мэндийн байгууллагын байршил, бүтэц, зохион байгуулалт, тусламж, үйлчилгээний төрөл, шатлал, эмнэлгийн болон сувиллын орны дээд хязгаарыг тогтоох талаар: Эрүүл мэндийн сайдын 2014 оны “Эмнэлэг, сувиллын орны дээд хязгаарыг батлах тухай” 51 дүгээр тушаалаар Төв аймгийн хэмжээнд эмнэлгийн нийт орыг 521 /Нэгдсэн эмнэлэг, сумын Эрүүл мэндийн төв 476 ор, хувийн хэвшлийн эмнэлэг 45 ор/ хэмээн тогтоосон байна.

8.1.10. Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг хангах асуудлыг холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлэх талаар: Борнуур сумын Эрүүл мэндийн төвийг улсын төсвийн 580.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2012 оноос 2013 онд шинээр барьж ашиглалтад оруулан, 2014 оны 01 дүгээр сард нээлт хийсэн. Эрүүл мэндийн сайдын 2013 оны 26 тоот тушаалаар эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах үйлст олон жил үр бүтээлтэй ажилласан 89 эмч, мэргэжилтнийг “Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан” цол тэмдгээр, 39 эмч, мэргэжилтнийг “Жуух бичиг”-ээр шагнаан урамшуулсан. Эрүүл мэндийн тухай хуулийн 29.5 дугаар заалтын дагуу **нэгдсэн эмнэлэг**, сум, өрхөд тогтвор суурьшилтай тасралтгүй ажиллаж байгаа 54 эмч, мэргэжилтэнд 143.2 сая төгрөг, тус хуулийн 29.2 дугаар заалтын дагуу өндөр насны тэтгэвэрт гарч байгаа 36 эмч, мэргэжилтэнд 437.2 сая төгрөг олгосон. Эрүүл мэндийн салбарт ажиллагсад /хүнд хортой нөхцөл/-ийн нэмэгдэлд 58.9 сая төгрөг олгож, 2013 онд үр дүнгийн урамшуулалд 410.6 сая төгрөгийн санхүүжилт төсөвлөгдсөнөөс 400.4 сая төгрөг олгосон.

8.1.13. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, хянах талаар: 2013 онд сайдын 38 тушаалын 50 заалтыг хэрэгжүүлж оны эцэст хэрэгжилтийг 90 хувийн биелэлттэйгээр тооцон Эрүүл мэндийн яаманд явуулсан байна.

8.1.16. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, эрүүл мэндийн байгууллага, үйлдвэрлэлийн стандартыг боловсруулж, эрх бүхий байгууллагатай хамтран батлах талаар: аймгийн Нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны стандарт MNS 5095:2013, сумын Эрүүл мэндийн төвийн стандарт болон Сувилалын стандартыг шинэчлэн боловсруулсан байна.

8.1.17. Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулах талаар: Энэхүү ажлыг Эрүүл мэндийн хөгжлийн төвөөр дамжуулан зохион байгуулж хэвшсэн байна.

8.1.18. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын бодлогын хэрэгжилтэд хяналт тавьж, эрүүл мэндийн байгууллагад магадлан итгэмжлэл олгох үйл ажиллагааг зохион байгуулах талаар: Магадлан итгэмжлэлд орох хүсэлтээ өгсөн 27 эрүүл мэндийн байгууллагад ЭМЯ-наас томилогдсон шинжээч нар ажиллаж, 23 эрүүл мэндийн байгууллагыг 3-5 жилээр магадлан итгэмжилсэн байна.

8.1.23. Эрүүл мэндийн ажилтныг төгсөлтийн дараах сургалтад хамруулах, мэргэшлийн зэрэг олгох үйл ажиллагааг зохион байгуулах талаар: Төгсөлтийн дараах сургалтад 21 сувилагч, тусгай мэргэжилтэнг төрөлжсөн мэргэжлийн болон давтан сургалтад, 20 эмч, мэргэжилтэнг давтан болон төрөлжсөн нарийн мэргэжлээр мэргэшүүлэх сургалт, резидентийн сургалтад хамруулсан байна.

2013 онд Эрүүл мэндийн сайд аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээгээ дүгнээгүй байгаа нь төсвийн тухай хуулийн 65.1.3-т “Холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчтай Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээг байгуулж ажиллах”, 40.3-т “Үр дүнгийн гэрээний биелэлтийг харьяалагдах дээд шатны төсвийн захирагч нь хагас бүтэн жилээр дүгнэнэ” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

2.2. Аймаг, сумын ИТХ эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар бүрэн эрхээ хэрэгжүүлж чадаж байна уу?

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар бүрэн эрхээ хэрэгжүүлэн ажиллаж байна.

Аймгийн ИТХ-аар 2013 онд Нийгмийн эрүүл мэндийн талаар 2012-2016 онд аймгаас баримтлах бодлого, Нийгмийн салбарын хүний нөөцийн бодлогын /2010-2015 он/ хэрэгжилтийн тайлан, мэдээлэл, “Эргэлтийн эмийн сан”-гийн хөрөнгийг бүртгэх өмчлөх тухай зэрэг асуудлыг хэлэлцэн тогтоол шийдвэр, тэмдэглэл гарган хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Нийгмийн эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын /2012-2016 он хүртэл/ хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 6 зорилт 28 хэрэгжүүлэх арга **хэмжээний** төлөвлөгөөний хэрэгжилтийг ИТХ-аар хэлэлцээд хэрэгжилт 67.5%-ийн биелэлттэйгээр дүгнэн, 8 зүйл арга хэмжээг хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтнуудад 56 тоот тэмдэглэлээр үүрэг болгон хүргүүлж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

“Нийгмийн боловсон хүчний бодлого”-ыг /2010-2015 онд/ хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 5 зорилт 25 арга хэмжээ 84.8%-ийн биелэлттэй байна.

Мөн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тавдугаар хуралдаанаар “Эрүүл аймаг, сум, баг, ажлын байр сургууль бий болгох үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хэлэлцэж шалгуур үзүүлэлтүүдийг орон нутгийн нөхцөл байдалд нийцүүлэн боловсронгуй болгон өөрчилж, хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргад даалгаж тэмдэглэлээр үүрэг өгсөн байна.

Аймгийн ИТХурал эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар бүрэн эрхээ хэрэгжүүлэн ажиллаж байна

2.3 Аймгийн Засаг дарга эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар бүрэн эрхээ хэрэгжүүлж байна уу?

Аймгийн Засаг дарга эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар хуулинд заагдсан бүрэн эрхээ хэрэгжүүлж ажилласан боловч Эрүүл мэндийн газрын даргатай үр дүнгийн гэрээ байгуулаагүй ажилласан байна.

Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалтын дагуу дараахь ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

11.1.1. Эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газар, нутгийн өөрөө удирдах байгууллагаас гаргасан шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах талаар: Аймгийн Засаг даргын 2013 оны “Зардал гаргах тухай” а/176 тоот захирамжаар 1.725.0 мянган төгрөг гарган, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар төрөөс баримтлах цогц бодлого болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, оролцоог хангах үндэсний хөтөлбөрийг шинээр боловсруулан гаргаж байгаатай холбогдуулан, аймгийн хэмжээнд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, хамгааллын бодлого-шинэчлэл” зөвлөгөөн зохион байгуулж, зөвлөгөөнд оролцогчдоос гарсан санал, хүсэлтийн дагуу аймгийн Засаг даргын Тамгын газарт хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан налуу зам тавьсан байна.

Аймгийн Засаг даргын “Тусгай зөвшөөрлийн комисс байгуулах тухай” а/497 тоот захирамжаар эрүүл мэндийн байгууллагуудад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн даргаар ахлуулан байгуулсан байна.

11.1.2. Харьалах нутаг дэвсгэртээ хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, ойрын ба хэтийн төлөвийг тодорхойлсон хөтөлбөр, төсөл боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж, гарсан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах талаар: “Эрүүл аймаг, сум, баг, ажлын байр, сургууль бий болгох” аймгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал, аймгийн

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн, дүгнэлт гаргуулж, аймгийн Засаг даргын 2013 оны а/296 тоот захирамжаар “Эрүүл аймаг, сум, баг, ажлын байр, сургууль бий болгох” аймгийн дэд хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт болон дэд хөтөлбөрийн орон нутгийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан байна.

“Нийгмийн салбарын боловсон хүчний бодлого”, “Нийгмийн эрүүл мэндийн талаар 2012-2016 онд аймгаас баримтлах бодлого” түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2013 оны хэрэгжилтийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал болон ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн тогтоол, тэмдэглэл гаргуулан, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

11.1.3. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн харьяалах нутаг дэвсгэрийнхээ эрүүл мэндийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, оновчтой байршуулах, материаллаг бааз, хүний болон санхүүгийн нөөцийг зохистой хуваарилах талаар: Аймгийн Засаг даргын 2013 оны “Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр тусламж үйлчилгээ үзүүлэх хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагыг сонгон шалгаруулах комисс томилох тухай” а/616 тоот захирамжаар байгуулагдсан комисс сонгон шалгаруулалт явуулж, аймгийн Засаг даргын 2013 оны а/643 тоот захирамжаар “Өвөржанчивлан”, “Задгай цагаан” рашаан сувилал, “Аксион” мэдрэлийн эмнэлэгт 2014-2015 онд Эрүүл мэндийн даатгалаас санхүүжүүлт авах эрх олгож, гурвалсан гэрээ байгуулан ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын 2013 оны “Эмийн эргэлтийн сан”-гийн удирдах зөвлөл байгуулах тухай а/209 тоот захирамжаар аймгийн хэмжээнд “Эмийн эргэлтийн сан”-г мэргэжлийн болон санхүүгийн удирдлагаар ханган ажиллах чиг үүрэг бүхий аймгийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг баталж, сумдад “Эмийн эргэлтийн сан”-гийн Хяналтын зөвлөлийг байгуулан ажиллах чиглэл өгч хэрэгжүүлэн ажилласан байна.

Эрүүл мэндийн байгууллагуудын тоног, төхөөрөмжийн хангалтыг сайжруулахаар Солонгос улсын Кангвон мужийн төр захиргааны байгууллага болон эрүүл мэндийн салбартай харилцаа холбоо тогтоон, эхний ээлжинд Нэгдсэн эмнэлгийн эмч, мэргэжилтнүүдийг сургаж, дадлагажуулах, тоног төхөөрөмжийн шинэчлэлд тусалцаа авахаар санал, хүсэлтээ өгсөний дагуу Солонгос улсын эмч, нар ирж Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлгийн ажил байдалтай танилцсан байна. Япон улсын “Өвсний үндэс” хөтөлбөр болон “Хүчитбаатар сан”-тай хамтран ажиллаж, Нэгдсэн эмнэлэг, Алтанбулаг сумын Эрүүл мэндийн төвд тус бүр 1 Япон улсад ашиглагдаж байсан яаралтай түргэн тусламжийн автомашин, “АСЕК” төрийн бус байгууллагатай хамтран Нэгдсэн эмнэлэгт 1 яаралтай түргэн тусламжийн автомашин авч өгсөн байна.

Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар Эрүүл мэндийн газраас эх, нялхас, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр 2012 онд зохион байгуулсан үйл ажиллагаа, үр дүнг хэлэлцэж, Засаг даргын 2013 оны “Эх, нярайн эрүүл мэндийн тусламжинд дэмжлэг үзүүлэх тухай” а/151 тоот захирамжаар Нэгдсэн эмнэлгийн эх барих эмэгтэйчүүдийн 4, хүүхдийн 4 эмчийг Баянхангай, Баянчандмань, Батсүмбэр, Борнуур, Бүрэн, Жаргалант, Угтаалцайдам, Цээл, Сүмбэр сумдад ажиллуулахад шаардлагатай 1.7 сая төгрөгийг шийдвэрлэн, эмч, мэргэжилтнүүдийг сумдад ажиллуулан, сумын эмч, мэргэжилтнүүдийг ажлын байранд нь дадлагажуулан, сургаж, эх, нярайн эндэгдлээс сэргийлэн ажилласан байна.

11.1.4. Байгалийн онц аюултай үзэгдэл болон олон улсын хөл хориот өвчин гарсан тохиолдолд шаардлагатай арга хэмжээг шуурхай авах талаар: Байгалийн онц аюултай үзэгдэл болон олон улсын хөл хориот өвчин гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2013 оны а/499 тоот захирамжаар “Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги”-ийг шинэчлэн байгуулж, ажил үүргийн хуваарийг тодорхой болгосон. Мөн гамшгаас хамгаалах арга хэмжээг боловсронгуй болгох зорилгоор аймгийн Засаг даргын 2013 оны “Гамшгаас хамгаалах удирдах бүрэлдэхүүний сургууль, дадлагын бэлтгэл хангах тухай” а/500 тоот захирамж гарган, а/503 тоот захирамжаар Гамшгаас хамгаалах удирдах бүрэлдэхүүний сургууль, дадлагын үед байгалийн голомтот болон гоц халдварт өвчин гарсан тохиолдолд дэлгэх хээрийн эмнэлэгт шаардагдах 4.4 сая төгрөг, Мал, амьтны гоц халдварт өвчний голомтот хээрийн мал эмнэлэг дэлгэхэд шаардагдах 3.2 сая төгрөгийг тус тус шийдвэрлэн, Гамшгаас хамгаалах удирдах бүрэлдэхүүний дадлага, сургуулийг зохион

байгуулсан байна. Аймгийн Засаг даргын 2013 оны “Гамшигаас хамгаалах сургалтуудыг зохион байгуулах тухай” а/192 тоот захирамжийн дагуу гамшгаас хамгаалах арга зүйн сургалтыг Сүмбэр, Дэлгэрхаан суманд, бүсчилсэн сургалтыг Баянхангай суманд тус тус зохион байгуулан ажилласнаар гамшиг, аюул, ослоос урьдчилан сэргийлж, ажилласан байна.

11.1.5. Эрүүл мэндийг хамгаалах, дэмжих чиглэлээр идэвх, санаачилгатай ажиллаж байгаа хамт олон, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах, сурталчлах ажлыг зохион байгуулах талаар: Жил бүр байгууллага, хамт олноо хошуучлан ажилласан аймгийн хөдөлмөрийн аварга эмч, сувилагч нарыг шалгаруулан урамшуулж, алдаршуулах ажлыг зохион байгуулж хэвшсэн. Эрүүл мэндийг хамгаалах, дэмжих чиглэлээр идэвх, санаачилгатай ажиллаж байгаа эрүүл мэндийн салбарын 20 гаруй эмч, мэргэжилтэнг аймгийн Засаг даргын “Хүндэт жуух”, “Хүндэт тэмдэг”-ээр шагнаж, урамшуулсан байна.

11.1.6. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын даргыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөн Төрийн албаны тухай хуулийн дагуу томилох, чөлөөлөх талаар: Эрүүл мэндийн газрын даргыг томилохдоо “Төрийн албаны тухай хууль”-ийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь заалт, УИХ-ын 2003 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 60 дугаар тогтоолыг үндэслэн сонгон шалгаруулалт явуулж, Төв аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2013 оны 16 дугаар тогтоол, Авилгатай тэмцэх газрын 2013 оны 03/7560 дугаар албан бичиг зэрэг хууль, эрх зүйн баримт бичгийг үндэсэн Эрүүл мэндийн сайдтай зөвшилцөн, аймгийн Засаг даргын 2013 оны 10 дугаар сарын 14-ны өдрийн б/562 тоот захирамжаар томилсон байна.

11.1.7. Харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтний нийгмийн баталгааг хангах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах талаар: Зуунмод суманд хэрэгжиж буй 1000 айлын орон сууцны хорооллын барилгын 1м² талбайн үнийг 1.0 сая төгрөгөөс хэтрүүлэхгүйгээр гэрээ хийн бариулж, төрийн албан хаагчид тэр дундаа эрүүл мэндийн салбарын эмч, мэргэжилтнүүдийг нэн тэргүүн оруулахаар төлөвлөж эхний ээлжинд ашиглалтад оруулах 128 айлын орон сууцны барилгын ажлыг эхлүүлсэн байна.

11.1.8. Харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагад нэмэлт санхүүжилт олгох талаар: Аймгийн Засаг даргын 2013 оны “Хүний дархлал хомсдолын вирус/дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх арга хэмжээнд зардал гаргах тухай” а/16 тоот захирамжаар салбар зөвлөлийн үйл ажиллагааны зардал 7.5 сая төгрөгийн төсвийг шийдвэрлэсэн байна. Аймгийн Засаг даргын 2013 оны “Заамар сумын Хайлааст багийн дунд сургууль, цэцэрлэг, хүн эмнэлгийн барилгын халаалтын асуудлыг шийдвэрлэх тухай” а/557 тоот захирамжаар Заамар сумын Хайлааст багийн дунд сургууль, цэцэрлэг, хүн эмнэлэг зэрэг байгуулагуудын халаалтын зуух, шугам, сүлжээний угсралтын ажилд шаардлагатай 164.9 сая төгрөгөөс 80.0 сая төгрөгийг 2013 оны аймгийн төсвийн хэмнэлтийн үлдэгдлээс гарган угсралтыг хийж, “Хөрөнгө шийдвэрлэх тухай” а/613 дугаар захирамжаар Заамар сумын Хайлааст багийн Дунд сургууль, цэцэрлэг, цагдаа, эмнэлгийн халаалтын зуухны цахилгааны засварын ажилд шаардлагатай 5.0 сая төгрөгийг орон нутгийн төсвийн хэмнэлтээс санхүүжүүлэн засварласан байна.

Аймгийн Засаг даргын 2013 оны “Төсвийн өр барагдуулах тухай” а/681 тоот захирамжаар Алтанбулаг, Баян, Баяндэлгэр, Баянчандмань, Бүрэн, Жаргалант, Заамар, Сүмбэр сумын Эрүүл мэндийн төв, аймгийн Нэгдсэн эмнэлгийн нийт 26.4 сая төгрөгийн өрийг аймгийн 2012 оны төсвийн шилжих үлдэгдэл, төсвийн хэмнэлт, хуваарилагдаагүй зардлын эх үүсвэрээс санхүүжүүлэн шийдвэрлэсэн байна.

11.1.9. Тухайн шатны эрүүл мэндийн байгууллагын удирдлагыг томилох, чөлөөлөх асуудлаар эрүүл мэндийн газрын даргатай зөвшилцөх талаар: Аймгийн Нэгдсэн эмнэлгийн даргыг томилох асуудлыг Эрүүл мэндийн газрын даргатай зөвшилцөн, Эрүүл мэндийн газрын даргын 2013 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн 92 тоот тушаалаар Нэгдсэн эмнэлгийн даргыг томилсон байна.

Аргалант, Баяндэлгэр, Баянцогт, Баянчандмань, Баянцагаан, Батсүмбэр, Лүн, Өндөрширээт, Угтаалцайдам, Мөнгөнморьт сумын Эрүүл мэндийн төвийн дарга /эрхлэгч/-

ын сул ажлын байрыг нийтэд зарлан, сонгон шалгаруулалт явуулж, 8 эрүүл мэндийн байгууллагын дарга /эрхлэгч/-ын албан тушаалд тэнцсэн иргэдийн тогтоолыг гарган, томилох эрх бүхий байгууллагуудад хүргүүлсэн байна.

11.1.10. Хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрхийн талаар: Аймгийн Засаг даргын “Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгө зарцуулах тухай” а/492 тоот захирамжаар “5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг бууруулах, нярайн эрүүл мэндийн чиглэлээр хийх үйл ажиллагааны ажлын удирдамж”, “Эрүүл мэндийг дэмжих сангийн санхүүжилтээр 2013 онд хийх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г батлан хэрэгжүүлсний үр дүнд эхийн эндэгдэл гаргаагүй. Эрүүл мэндийн яам, аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран “Эх, хүүхдийн эрүүл мэндийн төлөө хамтдаа” зөвлөгөөнийг зохион байгуулж, 27 сумын Засаг даргыг багийн дарга, Эрүүл мэндийн төвийн даргатай нь хамт оролцуулан, эх, хүүхдийн эндэгдэл, түүний шалтгаан, үр дагавар, эндэгдлээс урьдчилан сэргийлэхэд салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр мэдээлэл өгч, зөвлөмж гаргасан байна. Аймгийн Засаг даргын 2013 оны “Гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтнийг эрүүл мэндийн үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулах тухай” а/457 тоот захирамжийн дагуу гадаадын иргэд ажилладаг 15 аж, ахуйн нэгжийн 360 иргэнийг үзлэг, шинжилгээнд хамруулж, өвчтэй илэрсэн хүмүүсийг эмчлэн, эрүүлжүүлсэн байна.

2013 онд аймгийн Засаг дарга эрүүл мэндийн газрын даргатай үр дүнгийн гэрээ байгуулаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийг зөрчсөн байна. Үүнийг Эрүүл мэндийн газрын даргыг 2013 оны 4 дүгээр сард түр орлон гүйцэтгэгчээр, 2013 оны 10 дугаар сарын 14-ны өдрийн аймгийн Засаг даргын б/582 тоот захирамжаар Эрүүл мэндийн газрын даргын албан тушаалд томилсон нь оны эцсийн улирал эхэлсэн учир гэрээ байгуулаагүй гэж тайлбарлаж байв.

Аймгийн Засаг дарга эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар хуулинд заагдсан бүрэн эрхээ хэрэгжүүлж ажилласан боловч ЭМГазрын даргатай үр дүнгийн гэрээ байгуулаагүй ажилласан байна.

2.4 Сум, баг, хорооны Засаг дарга эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар бүрэн эрхийг хэрэгжүүлж байна уу?

Аймгийн хэмжээнд 5 суманд их эмчийн стандарт хангалт дутагдалтай, сумдад эмнэлгийн дунд мэргэжилтэн бага эмч, сувилагчийн хангалт 89.4 хувьтай байна.

Сумын Засаг дарга нар Эрүүл мэндийн тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газар, нутгийн өөрөө удирдах байгууллага, дээд шатны Засаг даргаас гарсан шийдвэрийн биелэлтийг сумандаа зохион байгуулах, сумын хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тэгш байдлыг ханган, эрүүл мэндийг дэмжих чиглэлээр аж, ахуйн нэгж байгууллага иргэдийг оролцуулах ажлыг зохион байгуулж, эрүүл мэндийн байгууллагын шаардлагатай боловсон хүчин, материаллаг баазаар ханган ажиллаж, сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгчийг аймгийн Эрүүл мэндийн газрын даргатай зөвшилцөн томилж байна.

Сумын их эмчийн хангамж урьд оныхтой харьцуулахад их эмчгүй сумын эрүүл мэндийн төвүүд байхгүй болсон байна. Эрхлэгч эмч албан ёсоор томилогдоогүй Баянцагаан, Баянчандмань, Мөнгөнморьт сумд байна. Батсүмбэр, Баянчандмань, Борнуур, Жаргалант, Сэргэлэн сумдын эрүүл мэндийн төвүүд байвал зохих орон тооноос тус бүр 1 эмч дутуу байна. 2012 онд 8 сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгчийг сонгон шалгаруулж, томилсон байна. Сумдад 2012 онд 58 их эмч ажиллаж байсан бол 2013 онд 60 их эмч ажиллаж байна.

Сумын Эрүүл мэндийн төвд ажиллаж буй их эмчийн стандарт хангалт 98%, сувилагч, тусгай мэргэжилтний стандарт хангалт 89.4%-тай байна. Иймд сумын засаг дарга нар сумын эмнэлгийн мэргэжилтэй ажилтнуудын стандарт хангалтыг хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байна.

Бүлэг 3

Эрүүл мэндийн байгууллагын тогтолцоо зөв байна.

3.1 Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр тусламж, үйлчилгээг үзүүлж чадаж байна уу?

Аймгийн эрүүл мэндийн салбарын зүгээс нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр тусламж, үйлчилгээг хангалттай үзүүлж байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурал, Засаг даргын зөвлөлийн хурлаар “Нийгмийн эрүүл мэндийн талаар 2012-2016 онд аймгаас баримтлах бодлого” түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2013 оны хэрэгжилтийг хэлэлцэн, ажил эрчимжүүлэх санал, зөвлөмж өгсөн байна. “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага” шалгаруулах Эрүүл мэндийн сайдын 184 дүгээр тушаал, Нийгмийн хөгжлийн хэлтсийн даргаар шинэчлэн батлуулсан



“Эрүүл мэндийг дэмжигч байгууллага шалгаруулах болзол”, журмыг 27 сумын Засаг даргад хүргүүлж, арга зүйн зөвлөмж өгч ажилласнаар 2013 онд 7 сумын 15 байгууллага “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага” болох зорилт тавин ажиллаж байгаа хүсэлтээ ажлын хэсэгт ирүүлснээс 10 байгууллагыг шалгаруулан, 1-3 дугаар зэргийн гэрчилгээ олгосон.

Зуунмод сумын Засаг даргын Тамгын газар, “Дэлхийн зөн” олон улсын байгууллагын Төв орон нутгийн хөгжил хөтөлбөртэй хамтран “Ажлын байрны эрүүл хэвшилд нэгдэцгээе” сэдэвт 2 сарын аян зарлаж, зохион байгуулалтын арга хэмжээ авсанаар 43 байгууллага, аж, ахуйн нэгж болзолын дагуу

материалаа ирүүлснээс эхний 5 байрыг шалгаруулан, урамшуулж, олон нийтэд сурталчилсан байна. Архи, тамхины хэрэглээ, тэдгээрийн нийгэм эдийн засагт учруулах сөрөг үр дагавар болон зан үйлийн өөрчлөлт, эрсдэлт хүчин зүйлийг бууруулахад чиглэгдсэн Эрдэм шинжилгээний онол практикийн бага хурлыг аймгийн хэмжээнд 2 дахь удаагаа нээлттэй зохион байгуулж, нийт 11 сумын 16 илтгэгч оролцож, эхний 3 байр, тусгай байрыг шалгаруулан, өргөмжлөл мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан. “Дэлхийн зөн” олон улсын байгууллагын Төв орон нутгийн хөгжил хөтөлбөр, Цагдаагийн газар, Зуунмод сумын Засаг даргын Тамгын газартай хамтран “Нийгэмд таны оролцоо” сургалт, зөвлөгөөн зохион байгуулж, архины хамааралтай 60 хүнийг хамруулсан. Мөн аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлтэй хамтран “Хуулиа дээдлэе” уриан дор “Архинд донтох өвчин” сэдвээр бүсчилсэн тэмцээнийг Баян, Баянцагаан, Эрдэнэсант, Цээл 4 суманд зохион байгуулж, 25 сумын 850 хүнийг хамруулсан байна.

“Хөдөлгөөн, хоол, архи, тамхины хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх” бүсчилсэн сургалтыг Баяндэлгэр, Заамар сумдад **зохион** байгуулж, 10 сумын 170 иргэнийг хамруулж, “Бага насны хоол тэжээл, бага насны хүүхдийн асаргаа сувилгаа”, “Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйл”-ийн талаар асуулт, хариултын тэмцээн явуулж, 20 төрлийн бага насны хүүхдийн хоолоор үзэсгэлэн гаргаж иргэдэд сурталчилсан. Баяндэлгэр, Заамар сумын Ерөнхий боловсролын сургуулийн 7-9 дүгээр ангийн 170 сурагч, Заамар сумын Мэргэжлийн

сургалт үйлдвэрлэлийн төвийн 60 сурагч, Хүмүүн цогцолбор сургуулийн дотуур байрны 85 сурагчдад “Архи, тамхины хор уршиг, Нөхөн үржихүйн эрүүл мэнд” сэдвээр сургалт зохион байгуулж, халдварт бус өвчний эрсдэлт зан үйлийг бууруулах чиглэлээр 5 төрлийн 700 ширхэг гарын авлага тараасан байна.

Иргэдийн нийгмийн эрүүл мэндийн мэдлэг, хандлагыг нэмэгдүүлэх зорилгоор хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр 35 удаа “Эрүүл мэндийн цаг” нэвтрүүлэг, 12 асуулт, хариултын тэмцээн, 7 гүүр шууд нэвтрүүлэг хийж, телевизийн шторк 4550 удаагийн давтамжтайгаар явуулж, эрүүл мэндийн Жаргалан сонины 8 дугаар 4000 ширхэгийг иргэдэд тараан, мэдээлэл сургалт, сурталчилгаа явуулж, ард иргэдийн эрүүл мэндийн мэдлэгийг дээшлүүлсэн. Аймгийн хүн амын эрүүл мэндийг хамгаалах, тэдэнд эрүүл аж төрөх боловсрол дадал эзэмшүүлэх, эрүүл орчин бүрдүүлэх зорилгоор халдварт болон халдварт бус өвчлөлийн чиглэлээр мэдээлэл сургалт, сурталчилгаа, өдөрлөг, бүсчилсэн уулзалт, зөвлөгөөн, үзүүлэх сургалт, тэмцээн уралдааныг давхардсан тоогоор 531 удаа зохион байгуулж, 62338 хүнийг хамруулсан нь нийт хүн амын 71.3%-ийг эзэлж байна.

Эрүүл мэндийн яамнаас жил бүр санхүүжүүлдэг хөтөлбөр төслийн урсгал зардалд 2013 онд нийт 102.0 сая төгрөг хуваарилагдан ирснийг Эрүүл мэндийн газар, сумын Эрүүл мэндийн төвүүдэд хүн амын тооноос хамааран хуваарилсан санхүүжилтийг сар бүр хуваарийн дагуу өгч, гүйцэтгэлд нь хяналт тавин ажиллаж байна.

Аливаа өвчлөлийг эрт илрүүлэх зорилгоор 2013 онд урьдчилан сэргийлэх үзлэгт давхардсан тоогоор 102551 хүнийг хамруулжээ. Архуст, Мөнгөнморьт, Заамар, Жаргалант, Батсүмбэр, Эрдэнэ суманд сүрьеэ, бруцеллёз, ДОХ/БЗДХ-ын эмч нар 12 хоног ажиллаж, 4813 хүнд үзлэг хийн, 3772 хүнийг серологи, сүрьеэ, бруцеллёзын шинжилгээнд хамруулж, 58 БЗДХ, 88 сүрьеэ өвчнийг илрүүлж, сумын эмчийн хяналтад эмчлэн, 196 хүнд сүрьеэ, бруцеллёз, БЗДХ-ын талаар мэдээлэл, сурталчилгаа хийсэн байна. Сүмбэр, Борнуур, Жаргалант, Баянчандмань, Батсүмбэр суманд дотор, мэдрэл, ЭХО, лаборатори, эх барих, эмэгтэйчүүд, шүд, хүүхдийн чиглэлээр нарийн мэргэжлийн эмч нарын баг ажиллаж, 2827 хүнд үзлэг хийж, 2440 хүнийг шинжилгээнд хамруулан, өвчтэй илэрсэн 2505 хүнд зөвлөгөө өгч, 2440 хүнийг эмчилгээнд оруулж, 26 хүнийг хяналтад авч, 62 хүнийг дээд шатны эмнэлэгт илгээсэн. Зуунмод **сумын** 6 багт нарийн мэргэжлийн эмч нарын явуулын баг ажиллаж 1712 хүнд үзлэг шинжилгээ хийсэн байна.

Эрүүл мэндийн яам, аймгийн Засаг дарга нарын хооронд байгуулсан гэрээгээ дүгнүүлээгүй боловч, тус гэрээний хавсралтанд дурьдсан зарим үзүүлэлтээс харахад эхийн эндэгдэл гаргаагүй, нялхасын эндэгдэл 5.81 промилээр, 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 8.95 промилээр буюу 0.81 промил болон буурч, Мянганы хөгжлийн зорилт болон гэрээний зарим шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан байна. Мөн БЗДХ-ын тархалтыг бууруулах ХДХВ/ДОХ-ын тархалтыг хязгаарлах, сүрьеэгийн тархалтыг бууруулах, эрт илрүүлэх, эмчилгээний чанарт тавих хяналтыг сайжруулах чиглэлээр хүн амын дунд хийх сургалт сурталчилгааг сайжруулах, эмнэлгийн орчин үеийн багаж, тоног төхөөрөмжөөр хангах, нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр батлагдсан бусад хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зэрэг ажлуудыг хэрэгжүүлсэн байна.

Аймгийн эрүүл мэндийн салбарын зүгээс нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр тусламж, үйлчилгээг хангалттай үзүүлж байна.

3.2 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар төв болон орон нутагт ямар байна?

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын шалгуур үзүүлэлт өнгөрсөн оноос сайжирч, аймгуудын чанарын дундаж үзүүлэлтээс дээгүүр байна.

Эрүүл мэндийн сайдын 2008 оны 176 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2009 оны “Эмнэлгийн тусламжийн чанарын удирдлагын тогтолцоог бэхжүүлэх нь” хөтөлбөрийг батлах тухай 66 дугаар захирамжийн хэрэгжилт 2013 онд 92%-ийн гүйцэтгэлтэй байна. Эрүүл мэндийн сайдын 2010 оны “Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын дотоодын хяналтыг эрчимжүүлэх тухай” 225 дугаар тушаал, Монгол улсын шадар сайд, Эрүүл

мэндийн сайдын 2012 оны хамтарсан 06/25 дугаар тушаалаар чанарын багийн шинэчлэгдсэн бүтэц бүрэлдэхүүнээр ажиллах үүрэг өгсөнөөр бүх эрүүл мэндийн байгууллагуудад чанарын алба, баг байгуулагдан үйл ажиллагаа нь тогтмолжсон байна. Чанарын албаны ажиллах чиг үүргийг тодорхойлсон “Удирдамж загвар батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2012.08.07-ны өдрийн 274 дугаар тушаалыг бүх эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлэн, Эрүүл мэндийн газрын цахим хуудсанд тавьж, эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөн, чанар хариуцсан мэргэжлтнүүдийн сургалтаар уг тушаалыг танилцуулан зааварчлага өгсөнөөр, чанар сайжруулах ижил мэргэжилтний үзлэг хийх, алдаа зөрчлөө бүртгэн мэдээлэх тогтолцоог бүрдүүлсэн байна. Жил бүр Эрүүл мэндийн газар, аймгийн Нэгдсэн эмнэлгийн хяналт шинжилгээ үнэлгээний багийнхан эрүүл мэндийн байгууллагуудад хагас, бүтэн жилээр хяналт, үнэлгээ хийж зөвлөн туслаж хэвшсэн байна. Эрүүл мэндийн байгууллагын эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын гол үзүүлэлт магадлан итгэмжлэлийн хувьд 2012, 2013 онд магадлан итгэмжлэгдэх хүсэлт гаргасан 27 эрүүл мэндийн байгууллагаас 23 эрүүл мэндийн байгууллага магадлан итгэмжлэгдсэн байна.

Эрүүл мэндийн сайдын 2012 онд аймгуудын эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааг дүгнээд өгсөн үүрэг зөвлөмжийн 7-д эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанрыг сайжруулах талаар өгсөн зөвлөмжийн хүрээнд олон талын ажил зохион байгуулж бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

2013 онд Эрүүл мэндийн сайд болон аймгийн Засаг даргын хооронд байгуулсан гэрээний 3.4.3-т Хүн амын дунд сүрьеэгийн тархалт нас баралтыг бууруулах зорилгоор эрт илрүүлэлт, төгс эмчилгээний чанарт тавих хяналтыг сайжруулах, Эрүүл мэндийн газрын жилийн ажлын төлөвлөгөөний 6.9-д Жаргалант Батсүмбэр, Эрдэнэ, Баянцагаан сумдад эмнэлэгийн тусламж үйлчилгээний чанар сайжруулах бүсчилсэн сургалт зохион байгуулах гэсэн хоёр заалтыг авч хэрэгжүүлсэн байна. Аймгийн хэмжээнд Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын статистик үзүүлэлтийг судалж үзэхэд 23 шалгуур үзүүлэлтийн 18 **биелсэн буюу 78.2%-тай байгаа** нь өнгөрсөн оныхоос сайжирсан. Дээрх үзүүлэлтүүд нь улс аймгийн дундажаас дээгүүр үзүүлэлттэй байна.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын шалгуур үзүүлэлт өнгөрсөн оноос сайжирч, аймгуудын чанарын дундаж үзүүлэлтээс дээгүүр байна.
Хавсралт№1

3.3 Эрүүл мэндийн хуулиар зохицуулагдаагүй асуудал байна уу?

Төсөв мөнгөний хүрэлцээгүй байдлаас болж эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдээр эм, тариа авахуулах тохиолдол зарим үед гардаг байна.

Хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой Эрүүл мэндийн тухай хуулиар зохицуулагдаагүй асуудал байхгүй байна. Гэвч зарим үед төсөв мөнгөний хүрэлцээгүй байдлаас болж эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдээс өөрсдөөр нь эм тариа авахуулах, суманд түргэн тусламжийн машины шатахууны зардлыг үйлчлүүлэгчээс зарим үед гаргуулан авч байгаа нь Монгол улсын үндсэн хуулийн 16.6, Эрүүл мэндийн тухай хуулийн 4.1, 24.6 дэх заалтыг тус тус зөрчиж байна. Энэ байдалд гүйцэтгэлийн аудитын явцад судалгаа хийж үзэхэд 2012 онд аймгийн Нэгдсэн эмнэлэг 9-н төрлийн 1456.7 мянган төгрөгийн, сумдын эрүүл мэндийн төвүүд 8-17 нэр төрлийн 504.1 мянган төгрөгийн эм эмнэлгийн хэрэгсэлийг хэвтэн эмчлүүлэгч иргэдээр гаднаас авчруулсан байна. 2013 онд аймгийн Нэгдсэн эмнэлэг 7 нэр төрлийн 646.0 мянган төгрөгийн, сумын Эрүүл мэндийн төвүүд 147.5 мянган төгрөгийн эм тариаг өвчтөн эмчлүүлэгчдээр өөрсдөөр нь авахуулсан байна.

Бүлэг 4


Эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцоог өөрчлөх шаардлагатай байна.

4.1 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилт нь: Хүн амын эрүүл мэндийг сайжруулах, хүн амд тэгш, хүртээмжтэй, чанартай эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэгдэхээр хуваарилсан байна уу?

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилт нь хүн амын эрүүл мэндийг сайжруулах, хүн амд тэгш хүртээмжтэй, чанартай тусламж, үйлчилгээ үзүүлэхэд хүрэлцдэггүй байна.

2013 онд санхүүжилтийн хувьд аймгийн Эрүүл мэндийн газар 1202.3 сая төгрөгийн, аймгийн Нэгдсэн эмнэлэг 3997.8 сая төгрөгийн төсөв, 26 сумын Эрүүл мэндийн төв болон хоёр өрхийн Эрүүл мэндийн төвд 5586.3 сая төгрөгийн, нийт 10786.4 сая төгрөгийн төсвийн зарлагыг батлагдсан хэмжээнд зарцуулан үйл ажиллагаагаа явуулж байна. Санхүүжилтийн бүтцийг авч үзвэл цалин шимтгэлд 73%-ийг, тогтмол зардалд 9%, эм хоол 8%, 1 удаагийн урамшуулал тэтгэмж 6%, тээвэр, шатахууны зардал 3% тус тус эзэлж байна. Энэхүү санхүүжилт нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүн амд хүртээмжтэй чанартай хүргэхэд төдийлөн хүрэлцдэггүй юм байна.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилт нь Сангийн сайд, ЭМ-ийн сайдын 2008 оны 21/81 тоот хамтарсан тушаалын дагуу үйлчлэх хүрээний хүн амын насны ангилалаар, санхүүжилтийн харьцааг жигнэсэн хүн амын тооцоонд үндэслэн эм, хоол, төсөл хөтөлбөрийн зардалд хуваарилдагч тусламж үйлчилгээний чанар, үр ашгийг нэмэгдүүлэхэд хүрэлцдэггүй гэж тайлбарлаж байв.



Эдгээрийн заримыг дурьдвал эмийн төсөв хүрэлцдэггүйгээс эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчид хувиараа эм тариа худалдан авч хийлгэх, сумдын түргэн тусламжийн машины шатахууны зардал хүрэлцдэггүй, эмнэлгийн ажилтнуудын цалин хөлс бага, эмнэлгийн орны хүрэлцээгүй байдал, ор хүлээлтийн хоног зарим ачаалалтай үед 30-45 хоног хүлээх гэх мэт бэрхшээлтэй асуудлууд нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилт нь хүн амын эрүүл мэндийг сайжруулах, хүн амд тэгш хүртээмжтэй, чанартай тусламж, үйлчилгээ үзүүлэхэд хүрэлцдэггүй байна. Мөн Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2008 оны 21/41 тоот хамтарсан тушаалын хавсралтаар баталсан “Нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн аргачлал”, “Үйл ажиллагааны гүйцэтгэлд үндэслэн хуваарилах

санхүүжилтийг зарцуулах заавар” зэргийг мөрдөж төсвийн санхүүжилтийг төлөвлөн хэрэгжүүлж байгаа нь цаг үеэсээ хоцорсон байгаа тул Төсвийн тухай шинэчлэгдсэн хуулийн хүрээнд болон эмнэлгийн тусламж үйлчилгээний өнөөгийн нөхцөл, шаардлагад нийцүүлэн өөрчлөх шаардлагатай байна.

Эрүүл мэндийн эмчилгээ, үйлчилгээнд тавих хяналт ямар түвшинд байна вэ?

Бүлэг 5

Эрүүл мэндийн эмчилгээ, үйлчилгээнд тавих хяналт зохих түвшинд явагдаж байна.

5.1 Эрүүл мэндийн эмчилгээ, үйлчилгээнд тавих чанарын хяналтыг дотоод аудитын алба, хөндлөнгийн /эрүүл мэндийн чанарын хяналтын орон тооны бус зөвлөл/ байгууллагаар хийлгэсэн байна уу?

Чанарын хяналтыг эрүүл мэндийн байгууллагын дотоод хяналтын багаар болон Мэргэжлийн хяналтын газрын шалгалтаар хийж илэрсэн алдаа, зөрчлийг арилгуулах арга зүйн зөвлөмж өгч хэрэгжүүлэн ажилладаг байна.

Эрүүл мэндийн сайдын 2010 оны “Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын дотоодын хяналтыг эрчимжүүлэх тухай” 225 дугаар тушаал, Монгол улсын шадар сайд, Эрүүл мэндийн сайдын 2012 оны хамтарсан 06/25 дугаар тушаал, Чанарын албаны ажиллах чиг үүргийг тодорхойлсон “Удирдамж загвар батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2012 оны 274 дугаар тушаалын дагуу эрүүл мэндийн эмчилгээ, үйлчилгээнд тавих чанарын хяналтыг аймгийн Нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд чанарын хяналтын болон дотоод хяналтын багаар дамжуулан хэрэгжүүлж алдаа зөрчлөө илрүүлдэг, мэдээлдэг тогтолцоонд орсон байна.

Аймгийн Эрүүл мэндийн газраас 2013 онд эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаанд Эрүүл мэндийн газрын даргаар батлуулсан тусгай удирдамж, үзүүлэлтийн дагуу хэлтсийн дарга нараар ахлуулсан 5 баг аймгийн Нэгдсэн эмнэлгийн 7 алба 11 тасаг, 3 нэгжийг хамруулан, үйл ажиллагаанд нь явцын хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, зөвлөн туслах ажлыг зохион байгуулсан байна. Мөн 211 үйлчлүүлэгч иргэдээс сэтгэл ханамжийн судалгааг авч дүгнэлт хийж, Нэгдсэн эмнэлгийн 11 тасгаас 100 арчдасны шинжилгээ авч, 23 нь эерэг гарсан байна.

Эрүүл мэндийн сайдын 2012 оны 26 тоот тушаалаар батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу Биндэръяа Зуунмод өрхийн Эрүүл мэндийн төвд хяналт шинжилгээ үнэлгээ хийхэд хангалтгүй дүгнэгдсэн тул нэг сарын хугацаатай ажил эрчимжүүлэх төлөвлөгөө гарган ажиллах үүрэг өгч, биелэлтийг тооцон ажилласан байна.

2013 онд магадлан итгэмжлэлд хамрагдаагүй Заамар, Аргалант, Лүн, Архуст сумдын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд Эрүүл мэндийн газрын мэргэжилтнүүд Хяналт шинжилгээ үнэлгээ хийж, зөвлөн тусалж ажилласан байна. Мөн Эрүүл мэндийн газрын даргаар ахлуулсан 4-5 хүний бүрэлдэхүүнтэй баг Өндөрширээт, Дэлгэрхаан, Баянхангай, Баянцогт, Угтаалцайдам, Цээл, Заамар, Мөнгөнморьт, Баянжаргалан, Баянцагаан, Сэргэлэн зэрэг 16 сумын Эрүүл мэндийн төвийн 2013 оны Эрүүл мэндийн яамнаас зарласан “Хариуцлага, хяналтыг сайжруулах” урианы жилийн ажлын хүрээнд 4 чиглэлээр 96 шалгуур үзүүлэлтийн дагуу хяналт шинжилгээ хийж, үнэлгээ дүгнэлт өгч, газар дээр нь мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангаж ажилласан байна.

Хөндлөнгийн хяналтыг Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчид эрсдэлд суурилсан төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн шалгалтыг Мэргэжлийн хяналтын газрын даргын баталсан удирдамжийн хүрээнд хэрэгжүүлж байна. 2013 онд эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын хяналтын улсын байцаагч, эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч, эм био бэлдмэлийн хяналтын улсын байцаагч нар

сумдын болон өрхийн эрүүл мэндийн төвүүд, аймгийн нэгдсэн эмнэлэг зэрэг байгууллагуудад төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн шалгалт хийж эрсдлийн үнэлгээг тогтоож зөрчлийг арилгуулсан байна. Мэргэжлийн хяналтын дээрхи шалгалтуудын дүгнэлтээр Эрүүл мэндийн тухай хуулийн 8-р зүйлийн 8.1.1, 19-р зүйлийн 19.1, 20-р зүйлийн 20.2, 20.2.2, 20.2.5, 25-р зүйлийн 25.1, 28-р зүйлийн 28.4.1, 28.4.3, 28.4.6, 33-р зүйлийн 33.1, 34-р зүйлийн 34.1, 35-р зүйлийн 35.1.1, 36-р зүйлийн 36.1, 36.2, 40-р зүйлийн 40.2, 40.3, 42-р зүйлүүд мөн хуульд нийцүүлэн нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан тогтоол, шийдвэр, дүрэм, заавар, стандарт, журмын хэрэгжилт аймгийн Нэгдсэн эмнэлэгт 78 хувь, сумдын эрүүл мэндийн төвүүдэд 66%, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 70%-тай гэж дүгнэгдсэн байна. Эрүүл мэндийн байгууллагуудад илэрсэн зөрчлийг арилгуулахаар эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, улсын байцаагчдын хамтарсан 445 заалттай 13 албан шаардлагаар үүрэг даалгавар өгч “Эрүүл мэндийн байгууллагуудад нийтлэг илэрсэн зөрчлүүдийн шалтгаан, түүнийг арилгах аргачлал”, “Чанарын албаны ажиллах журам, үйл ажиллагааны чиглэл”, “Дотоод хяналт шалгалт зохион байгуулах, илэрсэн зөрчлийг арилгуулах, үр дүнд хүрэх”, “Эмнэлгийн хог хаягдлыг ангилан, ялгах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, халдваргүйтгэх, устгах тухай”, “Эмийн зохистой хэрэглээ” зэрэг сэдвүүдээр эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулсан байна. Аймгийн Эрүүл мэндийн газар Мэргэжлийн хяналтын газартай хамтран сумын “Эмийн эргэлтийн сан”, эмнэлгийн эмийн сан, хувийн хэвшлийн эмийн сангууд зэрэг 46 нэгжид хяналт шалгалт хийж, Эмийн сангийн стандарт хэрэгжилтийг сайжруулахад анхаарах зөвлөмжийг Эрүүл мэндийн газрын даргын албан тоотоор хүргүүлж хэрэгжилтийг тооцон ажилласан байна. Эрүүл мэндийн газрын дэргэдэх Тусгай зөвшөөрөл олгох комиссын стандартын шаардлага хангаагүй үнэлэгдсэн 5 эмийн санд 3 дугаар улиралд гүйцэтгэлийн хяналт хийсэн байна.

2013 оны Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааг оновчтой хэрэгжүүлсэн үү?

ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан ЭМС-ын 2013 онд хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ, ЭМГ-ын даргын үр дүнгийн гэрээ биелсэн үү?

Бүлэг 1

Эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтийн хэрэгжилт хангагдсан байна

1.1 Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан эрүүл мэндийн салбарт 2013 онд хэрэгжүүлэх зорилт арга хэмжээ хэрэгжсэн үү?

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт эрүүл мэндийн салбарт 2013 онд хэрэгжүүлэхээр тусгасан нэг зорилт хэрэгжих хугацаа болоогүй байна.

Монгол улсын Засгийн газрын 2012 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд тусгасан эрүүл мэндийн салбарын холбогдох заалтыг аймгийн Хяналт-шалгалт, үнэлгээ, дотоод аудитын алба хяналтын картаар холбогдох газруудад хариуцуулан өгсөн байна.

Арга хэмжээний төлөвлөгөөний 139 дүгээр зорилт болох “Аймгийн эмнэлгүүдийг орчин үеийн оношилгооны төвтэй болгох” үйл ажиллагааны хүрээнд 2013 онд “Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-III” төслийн санхүүжилтээр аймгийн Нэгдсэн эмнэлэгт 10 эмчилгээний зориулалттай олон үйлдэлт ор, Нэгдсэн үндэстний байгууллагын Хүн амын сангаас “Ургийн гаж хөгжил оношилох” ЭХО аппарат өгч, 1 их эмчийг Солонгос улсад сургасан байна. Төрөх болон мэс заслын тасагт 12.4 сая төгрөгийн мэс заслын багажны иж бүрдэл, 21.6 сая төгрөгийн нярайн инкубатор, 3.4 сая төгрөгийн нярайн пульсоксиметр нийлүүлжээ. Сүрьеэгийн тасагт Глобаль сангийн санхүүжилтээр отсос, хүчилтөрөгч компьютер, цэр цуглуулах кабин авсан байна. Хүүхдийн тасагт Нэгдсэн үндэстний байгууллагын Хүүхдийн сангийн төслөөр телемедициний зориулалттай иж бүрэн компьютер, notebook, зурагт, дүрс дамжуулагч болон бусад хэрэгслүүдийг суурилуулж, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн сэхээн амьдруулах, эрчимт эмчилгээний тасагтай шууд холбогдож эмчилгээ, оношилгооны хамтарсан зөвлөгөө хийж байна.

Арга хэмжээний төлөвлөгөөний 185 зорилт болох “Эрүүл хот, сургууль, цэцэрлэг, хотын эрүүл мэнд” хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх” арга хэмжээний Монгол улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2014 онд хийхээр тусгасан тул хугацаа болоогүй байна.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 17.1 дэхь зорилт, Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогын 4.4.2 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11.4 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2010 оны Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дүрэм, үйл ажиллагааны чиглэлийг шинэчлэн батлах тухай 405 дугаар тушаал, “Аймгийн Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулах тухай” 2012 оны Эрүүл мэндийн яамны сайдын 250 дугаар тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор шинээр зохион байгуулагдан ажиллах Нийгмийн эрүүл мэндийн төвийг байгуулах тухай саналаа холбогдох тооцоо судалгааны хамт Эрүүл мэндийн яам, Нийгмийн Эрүүл Мэндийн Үндэсний Төвд албан ёсоор хүргүүлсэн боловч энэхүү зорилт хэрэгжээгүй 2014 оны төсөвт ч суугаагүй байна.

Аймгийн Засаг дарга эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар хуулинд заагдсан бүрэн эрхээ хэрэгжүүлж ажилласан боловч Эрүүл мэндийн газрын даргатай үр дүнгийн гэрээ байгуулаагүй тул гэрээний биелэлтийг гаргаж дүгнэсэн зүйл байхгүй байна.

1.2 2013 онд аймгийн Засаг даргын Эрүүл мэндийн сайдтай байгуулсан гэрээ биелсэн үү?

Эрүүл мэндийн сайд аймгийн Засаг даргын хооронд байгуулсан Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөл хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээгээ дүгнээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 40.3 дахь заалтыг зөрчсөн байна.

Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагч болон аймаг, нийслэлийн Засаг даргын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөл хэрэгжүүлэх талаар 2013 онд байгуулсан гэрээнд Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагч бөгөөд захиалагчийн эрх үүргийг гэрээний 2.1-2.9 дэх заалтын 9 арга хэмжээг, төлөөлөл хэрэгжүүлэгч аймгийн Засаг даргын эрх үүргийг гэрээний 3.1-4.5-д заасан 47 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусган гэрээг байгуулсан байна. Уг гэрээний 8.6-д Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагч гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавьж 2014 оны 2 дугаар сарын 20-ны дотор багтаан энэхүү гэрээг дүгнэж, Төрийн албаны зөвлөлд хүргүүлнэ гэж заасан байна. Гэтэл энэхүү гэрээгээ дүгнээгүй байна. Аймгийн Засаг даргын гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлт гаргавал зохих 47 заалт арга хэмжээний 38.3% буюу 18 заалт арга хэмжээний хэрэгжилтийг гэрээний биелэлт гэж гарган 2014 оны 2 дугаар сарын 28-нд Нийгмийн хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн С.Бүжмаа гаргаж уг хэлтсийн дарга Б.Нямсүрэн хянаж аймгийн Засаг даргын 2014 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 01/324 тоот албан бичгээр Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн боловч гэрээний биелэлтийг хугацаа хожимдуулсан гэсэн үндэслэлээр дүгнээгүй гэж аймгийн ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн

хэлтсийн зүгээс тайлбараж байна. Мөн Эрүүл мэндийн яамнаас жил бүр зохион байгуулагддаг удирдах ажилтны зөвлөгөөнөөр Төв аймгийн Засаг даргын сайдтай байгуулсан гэрээний хэрэгжилтээ ирүүлээгүй улмаас сайдтай байгуулсан гэрээний хэрэгжилтийг 29%-ийн биелэлттэй гэж дүгнэсэн гэдгийг мэдсэн гэж тайбарлаж байв. Нийгмийн хөгжлийн хэлтсээс Эрүүл мэндийн сайдтай байгуулсан гэрээний хэрэгжилтийг хугацаанд нь гаргаж бүрэн гүйцэд тайлагнаагүй холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох нь зүйтэй гэж чиглэл өгсөний дагуу Эрүүл мэндийн газрын даргын тушаалаар ЭМГ-ын Эдийн засагч Д.Пүрэвдашид сахилгын шийтгэл ногдуулсан байна. Энэхүү гэрээний хэрэгжилтэд байнга хяналт тавин ажиллаж хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий албан тушаалтан Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга Б.Нямсүрэн, Эрүүл мэндийн газрын дарга Ч.Алтантуул нарын ажлын уялдаа холбоо муу, хариуцлагагүй үйл ажиллагаанаас болсон байна. Төрийн албаны зөвлөлийн 34-р тогтоолын 2-р хавсралтаар баталсан Эрүүл мэндийн газрын даргын ажлын байрны тодорхойлолтын 2.5-д “Аймгийн Засаг дарга болон төсвийн ерөнхийлөн захирагчийн хооронд бүтээгдэхүүн нийлүүлэлт санхүүжилтийн талаар байгуулсан гэрээнд заасан бүтээгдэхүүний биелэлтийг эрүүл мэндийн байгууллагуудаар хангуулах, үр дүнг тооцох, аудит хийлгэн дүгнэлт гаргуулах, шаардлагатай арга хэмжээ авах” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна. Мөн Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга, тус хэлтсийн Эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтонд энэ талаар тусгаагүй бөгөөд, эдгээр албан тушаалтнуудтай томилсон байгууллага болох аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээг 2013 онд байгуулаагүй байна. Иймд Нийгмийн Хөгжлийн хэлтсийн даргын ажлын байрны тодорхойлолт, төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээнд салбарын сайдтай байгуулах гэрээний хэрэгжилтийг хариуцуулах нь зүйтэй байна.

2013 онд Эрүүл мэндийн сайд аймгийн Засаг даргын хооронд байгуулсан Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөл хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээгээ дүгнээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 65.1.3, 40.3 дахь заалтыг зөрчсөн байна.

1.3 Эрүүл мэндийн үндсэн үзүүлэлт, түүний хэрэгжилт хангагдсан уу?

Эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтийн хэрэгжилт хангагдсан байна.

2013 онд эхийн эндэгдэл гаргаагүй. 2012 онд нялхсын эндэгдлийн түвшин амьд төрсөн 1000 хүүхдэд 19.52 промилль байсан бол 2013 онд 13.71, 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 9.76 промилль байсан бол 0.81 болон буурч, Мянганы хөгжлийн зорилт болон сайдтай байгуулсан гэрээний шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан. Дархлаажуулалтын хамралт 99.0%-д хүрсэн. Сумын Эрүүл мэндийн төвийн 81.8% нь магадлан итгэмжлэлээ авч, бүх сум их эмчтэй болсон байна.

Артерийн даралт ихсэх өвчин, чихрийн шижин хэв шинж 2 өвчний эрт илрүүлгийн үзлэг урьд оныхоос 1.9-3.4%-иар нэмэгдсэн байна. 2012 онд халдварт өвчний нийт 854 тохиолдол бүртгэгдэн 10.000 хүн амд 96.94 байсан бол 2013 онд 728 тохиолдол бүртгэгдэн, 82.87 болон буурч, эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааг төдийгүй аймаг, орон нутгийн үйл ажиллагааг үнэлж, дүгнэдэг үндсэн үзүүлэлтүүд эерэг дүнтэй гарсан байна.

Эрүүл мэндийн үзүүлэлтүүдийг сүүлийн 3-н жилээр харуулбал дараах байдалтай байна.

№	Үзүүлэлтүүд	2011	2012	2013
1.	Эхийн эндэгдэл /100000 амьд төрөлтөнд/	0	177.46	0
2.	1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл /амьд төрсөн 1000 хүүхдэд/	27.09	19.52	13.71
3.	1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл /амьд төрсөн 1000 хүүхдэд/	5.42	9.76	0.80
4.	Стационарт эмчлэгдсэн өвчтөний тоо	15602	15436	15085

5.	Ор хоног	130551	125301	122087
6.	Бүх нас баралт	439	441	369
7.	Эмнэлэгт нас барсан бүгд	73	68	61
8.	Үүнээс хоног болоогүй нас баралтын хувь	42.46	47.05	21.31
9.	Жирэмсний хяналтад эхний 3 сартай авсан хувь	86.47	87.88	86.91
10.	Бүгд үзлэг	266934	256448	247090
11.	Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь	39.47	42.58	41.50
12.	Түргэн тусламжийн дуудлага бүгд	18217	18823	17917
13.	Үүнээс алсын дуудлага	5117	5087	4494
14.	Халдварт өвчин бүгд /10000 хүн амд/	110.0	96.94	82.87

Эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтийн хэрэгжилт хангагдсан байна.

Улсын төсвийн хөрөнгөөр 2013 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байна уу?

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг үндэслэлтэй төлөвлөсөн үү?

Бүлэг А

Хөрөнгө оруулалтын эх үүсвэр нь зураг төсвийн дагуу батлагддаггүй байна.

А.1 Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг Үндэсний хөгжлийн цогц бодлого, МУ-ын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдуулан боловсруулсан уу?

Аймгийн ИТХ-аас 2009 онд батласан төлөвлөгөөний дагуу хөрөнгө оруулалт, их засварын ажлууд хийгдэж байна.

2013 онд аймгийн хэмжээнд нийт 10 төрлийн эх үүсвэрээр 399.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж болон хөрөнгө бий болжээ. Үүний 35%-ийг иргэдийн хандив тусламжаар, 26%-ийг “Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр III” төслөөр, 24%-ийг ЭМЯ, НҮБ-ын хүн ам болон хүүхдийн сантай хамтран хэрэгжүүлж буй төслөөр нийлүүлэгдсэн тоног төхөөрөмж байна.

2013 онд нийлүүлэгдсэн тоног төхөөрөмж, хөрөнгийн судалгаа

№	Эх үүсвэр	Сумдад	Нэгдсэн эмнэлэг	Бүгд	Хувь
1.	Хандив, тусламж	73401784	67851466	141253250	35
2.	Эмийн эргэлтийн сан	849900		849900	0.2
3.	Аймгийн БХСан	15000000		15000000	4
4.	ЭМСХХ-3	50664917	53472199	104137116.1	26
5.	ЭМЯам	19,252,142	78189254	97441396	24
6.	ДЗОУБ	3020355		3020355	1

7.	ЭМГ	1309735		1309735	0.3
8.	ХӨСҮТ	21651613		21651613	5
9.	ОН-ийн төсөв	1468000		1468000	0
10.	Сум хөгжүүлэх сан	12859000		12859000	3
Нийт дүн		199477446.1	199512919	398990365.1	100

Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагч болон аймаг, нийслэлийн Засаг дарга хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээгээр Төв аймагт улсын төсвийн хөрөнгөөр 2013 онд нийт 566.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэхээс 773.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Борнуур сумын 15 ортой эмнэлгийн 2012-2013 онд шилжих барилга 338.6 сая төгрөг, Баянцагаан, Сэргэлэн сумын эрүүл мэндийн төвийн барилгын их засварт 180.0 сая төгрөг, аймгийн ЭМГ-ын барилгын засвар, тохижилтод 48 сая төгрөг батлагдсныг 2012 оны 12 дугаар сарын 12-ны Эрүүл мэндийн сайдын 412 тоот тушаалаар “Эрх шилжүүлэн ажил гүйцэтгэх тухай” тушаалаар 228.0 сая төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх 3 хөрөнгө оруулалт, их засварын ажлыг орон нутагт шилжүүлсэн байна.

2013 онд улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн барилга, их засварын судалгаа
/мян.төг/

№	Сумын нэр	Барилгын нэр	Төсөвт өртөг	Батлагдсан хөрөнгө	Тендер	Гүйцэтгэл	Эх үүсвэр	Гүйцэтгэгч	Гүйцэтгэл	Захиалагч
1.	Борнуур /2012-2013/	ЭМТ-ийн барилга	773800 /580000/	338.600	567.645	524.202	Улсын төсөв	Баганат өргөө	70%	Яам
2.	Сэргэлэн	ЭМТ-ийн барилгын засвар	156.600	80.000	79.800	79.800	Улсын төсөв	Аслаан ХХК	100%	ЭМГазар
3.	Аймгийн ЭМГ	Барилгын засвар	180200	48000	47913	47913	Улсын төсөв	Арбулаг ХХК	100	ЭМГазар
4.	Баянцагаан	ЭМТ-ийн барилгын засвар	178.200	100.000			Улсын төсөв		0%	ЭМГазар
5.	Баян	Халаалтын тогоо	24094.3	24094.3	23.905	23.905	ЭМЯ, Гамшгийн нөөцийн зардал	Өндөрлөг ХХЗ	100%	ХА
Нийт дүн			1.288.800	566.600	719.263	675.820				

Үүнээс гадна Баян сумын эмнэлэгт нийт 102.5 сая төгрөгийн ажлыг хийж гүйцэтгэсний 23.9 сая төгрөгийн халаалтын тогооны ажлыг Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2013 оны төсвийн багцад батлагдсан эрүүл мэндийн байгууллагуудын “Гэнэтийн хүчин зүйлийн дагуу хийгдэх засварын хөрөнгө”-нөөс, дээврийн засвар 41.9 сая төгрөгийн ажлыг “ЭМСХХ-3” төслөөс, гадна фасад 32.4 сая төгрөгийг хандив тусламжаар, гадна тоглоомын талбайн тохижилт 3.4 сая төгрөгийг сумын “Сум хөгжүүлэх сан”-гийн эх үүсвэрээр гүйцэтгэжээ.

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2009 оны “Нийгмийн салбарын барилгад их засвар, өргөтгөл хийх, шинээр барих ээлж дараалал тогтоох тухай” 28 тоот тогтоолоор батлагдсан “Хүн эмнэлгийн барилгад их засвар, өргөтгөл хийх, шинээр барих ээлж дараалал”-д 26 сум, аймгийн ЭМГ, нэгдсэн эмнэлэг, өрхийн нийт 35 барилгын 27 барилгад их засвар, 3 барилга шинээр, 5 барилгад өргөтгөл хийхээр ээлж дараалал тогтоосон байна. **Эдгээрээс өнөөдрийн байдлаар сумын ЭМТ-ийн барилгад сая төгрөгийн хөрөнгө оруулалт, их засварын ажлыг хийж гүйцэтгэсэн байна.**

А.2 Төсвийн тухай хуулиар төсөл, арга хэмжээг батлахдаа ТЭЗҮ, баталгаажуулсан зураг төсвийг үндэслэсэн үү?

Барилгын засвар, хөрөнгө оруулалтын ажлын хөрөнгийн эх үүсвэр нь зураг, төсвийн дагуу батлагддаггүй байна.

МУ-ын “Төсвийн тухай” хуулийн 28.6-д “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 28.3.2, 28.3.3-т заасан эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг харгалзан үзэхэд үр дүнтэй болох нь урьдчилсан судалгаагаар тогтоогдсон нөхцөлд зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэлийн тооцоо хийнэ”, 29.4-т “Хөрөнгө оруулалтын төсөвт техник эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл арга хэмжээг тусгана” гэж заасан байна.

Аймгийн эрүүл мэндийн салбарт 2013 онд шинээр улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэхээр батлагдсан 3 ажил буюу Баянцагаан сумын Эрүүл мэндийн төвийн барилга 2012 онд 178.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй засвар хийгдэхээр батлагдсан боловч 100 сая төгрөг, Сэргэлэн сумын хүн эмнэлгийн барилгын засвар 2011 онд 156.6 сая төгрөгийн өртөгөөр хийж гүйцэтгэхээр зураг төсөв нь хийгдсэн боловч 2013 онд 80 сая төгрөг батлагдаж ирснээр 86.9 сая төгрөгийн ажлыг хийж гүйцэтгэхээр зураг төсөв нь батлагдсан төсвөөс хамааран өөрчлөгдсөн байна.

Худалдан авах ажиллагааг үр дүнтэй зохион байгуулсан уу?

Бүлэг Б

Худалдан авах ажиллагааг ТБОНӨХБАҮХАТухай хуулийн дагуу явуулаагүй байна

Б.1 Худалдан авах ажиллагааны аргыг оновчтой сонгосон уу?

Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах ажиллагаа нь ТБОНӨХБАҮХАТухай хуулийг зөрчжээ.

Аймгийн ГХБХГазар болон ХААлбанаас эрүүл мэндийн салбарт эрх шилжиж ирсэн хөрөнгө оруулалт, засварын ажлыг нээлттэй тендер 1, харьцуулалтын аргаар 2, ЭМГ-аас эм, эмийн хэрэгслийн худалдан авах ажиллагааг нээлттэй тендер шалгаруулалтаар зохион байгуулж явуулснаас 100,0 сая төгрөгийн Баянцагаан сумын Эрүүл мэндийн төвийн барилгын засварын ажлын нээлттэй тендер шалгаруулалтаар шаардлага хангах компани байхгүйгээс уг ажил хийгдээгүй байна. Харьцуулалтын аргаар худалдан авалт нь хийгдсэн Эрүүл мэндийн газрын барилгын их засварын ажлын зураг төсөв нийт 180.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2010 онд хийгджээ. 2010 онд 68.8 сая төгрөгөөр дээвэр, цахилгаан, халаалтын засварын ажил, 2013 онд барилгын гадна фасад, гадна хашаа, зам талбайн засварын ажлыг 48 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн байна. Сэргэлэн сумын эмнэлгийн барилгын засварт 80 сая төгрөг батлагдаж ирснээр батлагдсан төсөвт багтаан хэсэгчилж төсвийг 86.9 сая төгрөгийн ажил хийхээр өөрчилжээ. Энэ нь хяналтын төсвөөрөө нээлттэй тендер шалгаруулалт, батлагдсан хөрөнгийн эх үүсвэрээрээ харьцуулалтын арга хэрэглэхээр байна. Уг ажлыг батлагдсан хөрөнгийн эх үүсвэрт багтаан 86.9 сая төгрөгийн ажлыг 80.0 сая төгрөгт багтаан хийж гүйцэтгэхээр зураг төсөв дахин хийгдсэн нь төсөв хэмнэгдэх боломжтойг харуулж байна.

Төв аймгийн эмнэлгүүдийн хэрэгцээнд эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх нээлттэй тендер шалгаруулалтыг өвчний ангилал болон төрөл хэлбэрээр нь 19 багц болгон явуулжээ. 2013, 2014 онуудад эм, эмнэлгийн хэрэгслийн захиалгыг зайлшгүй шаардлагатай эмнэлгийн хэрэгслийн жагсаалт, эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах тендерийн жишиг баримт бичгийн “Эмийн багцын жишиг загвар”-ыг тус тус үндэслэн багцалж, АНЭ, сумын эрүүл мэндийн төвүүдээс захиалга авч явуулсан байна. Үүнд 425-480 нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл, лабораторийн урвалж бодисын, 92 нэр төрлийн эмнэлгийн хэрэгсэл, 72 нэр төрлийн урвалж, оношлуур, 261 төрлийн зайлшгүй шаардлагатай эмийг 19 багц болгон нээлттэй тендер шалгаруулалтын урилгын зарыг Сангийн яамны вэб сайт www.e-procurement.mn сайт, “Зууны мэдээ” сонинд тавьсан байна.

Аймгийн эрүүл мэндийн салбарт эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах болон аймгийн Засаг даргын багцад батлагдсан 2013 онд 519244,1 мянган төгрөг, 2014 онд 713612,4 мянган төгрөгнөөс АНЭ, сумдын эрүүл мэндийн төвүүдийг онцгой тохиолдолд эм, эмнэлгийн хэрэгсэл, цус, цусан бүтээгдэхүүн авах нөхцөл үүсэх зэргийг тооцон ерөнхий менежерийн эрхэнд эмийн төсвийн 20-30 хувийг үлдээхээр тооцож тендерийг зарлажээ. Тендерийн баримт бичгийн бүрдлийг эм ханган нийлүүлэх болон үйлдвэрлэх 13-23 компани худалдан авснаас 13-18 компани тендерийн баримт бичгээ ирүүлж, 1 компани тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш материалаа ирүүлсэн тул хасагдсан байна.

2013 онд тендер шалгаруулалтаар 11 компани 415395,0 мянган төгрөгийн эм, эмийн хэрэгслийг 364515,6 мянган төгрөгөөр нийлүүлэхээр гэрээ хийгдэж 50879,0 мянган төгрөг, 2014 онд 570889,9 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг 497562,3 мянган төгрөгөөр худалдан авахаар гэрээ хийж 73327,6 мянган төгрөг, нийт 124206,6 мянган төгрөгийн тендерийн хэмнэлт гарсанд акт, албан шаардлага бичихээр шийдвэрлэлээ.

Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авалтын аргаа зөв сонгоогүй, хуулиа бүрэн судалж ойлгоогүй, үндэслэлээ зөв гаргаагүйгээс ямар ч хуулийн үндэслэлгүй нийт үнийн дүнгийн 80 хувьд тендерийг явуулсан нь ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 8.7.1-д “Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо бүх багцын нийлбэр өртгийг үндэслэл болгох” гэсэн заалтыг зөрчиж худалдан авалтыг явуулсан байна.

Мөн тендерийн хэмнэлтийг зарцуулсан нь “Төсвийн тухай хууль”-ийн 42, 45 дугаар зүйл, ЭМ-ийн төсвийн ерөнхийлөн захирагч болон аймгийн Засаг дарга хооронд ЗГ-ын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний 3.18 дугаар заалтыг зөрчин Төсвийн ерөнхийлөн захирагчаас бичгээр зөвшөөрөл авалгүй зарцуулжээ.

Үүнээс гадна хоол, хүнсний материал болон ажлын хувцас хангалтыг ТБОНӨХБАҮХАТухай хуулийн дагуу худалдан авалтыг хийдэггүй байна.

Б.2 Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан уу?

Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа хугацаа алдаж зохион байгуулагдснаас 100,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийгдээгүй байна.

2013 онд эрх шилжиж хийгдсэн ЭМЯ-ны хөрөнгөөр 4, ЭМСХХ-3 төслийн 1, эм, эмнэлгийн хэрэгслийн 1, нийт 6 худалдан авах ажиллагааг зохион байгуулж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулжээ. Үүнээс барилгын засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил нээлттэй тендерээр 1, харьцуулалтын аргаар 4-ийг зохион байгуулжээ.

Баянцагаан сумын Эрүүл мэндийн төвийн барилгын 100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй их засварын ажлыг зохион байгуулах үнэлгээний хороо аймгийн Засаг даргын захирамжаар 7 сарын 31-нд байгуулагдаж, тендер шалгаруулалтыг 09 сарын 18-нд явуулж, тендерт материалаа ирүүлсэн 2 компани шаардлага хангаагүйгээс тендерийг дахин зарлахаар үнэлгээний хорооноос шийдвэрлэсэн боловч МУ-ын ЗГ-ын 2013 оны 09 сарын 21-ны өдрийн “Монгол улсын 2013 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах тухай” 324 дүгээр тогтоолын 2-т “Төсвийн гүйцэтгэлтэй уялдуулан 2013 оны 08

дугаар сарын 23-ний өдрийн байдлаар хууль тогтоомжийн дагуу тендер нь зарлагдаж, сонгон шалгаруулалт хийгдээгүй бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зогсоох”, “Хөрөнгө оруулалтын ажлыг 2013 онд багтаан гүйцэтгэх боломж, ажлын стандарт, чанарт тавигдах шаардлага зэргийг харгалзан 2013 оны 08 дугаар сарын 23-ний өдрийн байдлаар гэрээ байгуулагдаагүй байгаа хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний эхлэх хугацааг хойшлуулах” гэсний дагуу худалдан авах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил хийгдээгүй байна.

Энэ нь Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагч болон аймгийн засаг дарга хооронд байгуулсан гэрээний 3.22-т “ТБОНӨХБАҮХАТухай” хуулийн дагуу төсөвт өртгийн хэмжээнээс хамааран эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааг 2013 оны 02 сарын 01-ны дотор зарлан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй хугацаа алдаж худалдан авалтыг хийж, гүйцэтгэгчийг шалгаруулаагүйгээс эрүүл мэндийн салбарт ялангуяа хөдөө орон нутагт хийгдэх хөрөнгө оруулалтын ажил хийгдээгүй байна.

Хөрөнгө оруулалтын төсөл арга, хэмжээний хэрэгжилт бодитой байна уу

Бүлэг В

ЭМЯ-наас хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын үр дүн хангалтгүй байна.

В.1 Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд тусгай нөхцөл, хариуцлага тооцох асуудал бүрэн тусгагдсан уу?

Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд хариуцлагын асуудал бүрэн тусгагдаагүй байна.

2013 онд хийгдсэн хөрөнгө оруулалт, их засварын ажлын гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд тусгай нөхцлийг тусгажээ. Гэвч гүйцэтгэгчийн гэрээгээ биелүүлээгүй, ажлын чанар, хугацаа зэрэг гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд ямар хариуцлага хүлээх нь тодорхой бус, хариуцлагын талаар гэрээнд хангалттай тусгаж өгөөгүй байна. Гэрээнд “Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хариуцлагыг хүлээнэ”, “Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна” гэсэн 2 заалтаас өөр хариуцлагын талаар ямар нэгэн заалт байхгүй байна. “Гэрээнд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ”, “зөрчил гологдлыг арилгах үүрэг хариуцлагыг хүлээнэ” гэж байгаа боловч тусгай нөхцөлд нь хариуцлагын талаар нэг ч үг өгүүлбэр тусгаагүй, зөрчил гологдол гаргасан, мөн захиалагчийн зүгээс гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд ямар хариуцлага хүлээх талаар байхгүй байна.

В.2 Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг дүгнэж, үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчид хариуцлага тооцсон уу?

Ашиглагч байгууллагын төлөөлөлийг оролцуулан ажил хүлээлцэх комисс ажиллуулсан байна.

2013 онд эрх шилжиж хийгдсэн засварын ажлыг ашиглагч байгууллагын төлөөлөлийг оролцуулан барилгын засварын ажлыг хүлээлцэх комисс томилж ажиллуулан, комисс хуралдаж зарим дутуу ажлуудыг гүйцэтгүүлэх саналыг гүйцэтгэгч компанид тавьж хийлгүүлэн, ГХБХБГазар гэрээг дүгнэж, гэрээ дүгнэсэн акт үйлдэж барилгыг хүлээж авчээ.

Харин ЭМЯ-наас худалдан авалтыг зохион байгуулж, 2012-2013 онуудад он дамжин хийгдсэн Борнуур сумын ЭМТ-ийн барилгын ажил өнөөдрийг болтол бүрэн дуусаагүй 2013 оны жилийн эцсийн тайланд 580,0 сая төгрөгийн дуусаагүй барилгаар бүртгэгджээ. Шалгалтын явцад аймгийн ГХБХБГазар, ЭМГ-аас тодруулахад уг барилгын талаар ямар ч мэдээлэл, баримт материал байхгүй, гүйцэтгэгч компани болох “Баганат өргөө” ХХК-ий захирал Батсайхан, нягтлан бодогч нартай утсаар холбогдож тодруулахад анхны төсөвт өртөг нь 580,0 сая төгрөг, 2012 онд 567,6 сая төгрөгөөр хийж гүйцэтгэхээр ЭМЯ-тай гэрээ байгуулж 2013 онд 524,2 сая төгрөгийн санхүүжилт авсан бөгөөд ажлыг гүйцэтгэх явцад 311,0 сая төгрөгөөр өртөг нь өсч 878,6 сая төгрөг болсон байна.

Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагч болон аймгийн засаг дарга хооронд байгуулсан 2013 оны гэрээнд уг барилгын төсөвт өртөг 773,6 сая төгрөг байгаа нь уг барилгын хувьд нягтлан бодох бүртгэлийн тайланд тусгасан үнэ, авсан санхүүжилт болон барилгын төсөвт өртгүүд хоорондоо зөрүүтэй зөрчил байна.

В.3 Барилга байгууламж, тоног төхөөрөмжийг хүлээн авч, бүртгэлд тусган, бүрэн хүчин чадлаар ашиглаж байна уу?

2006 онд буцаан татаж авсан хөрөнгө дансанд бүртгэлтэй байна.

Барилга байгууламж, тоног төхөөрөмжийн бүртгэл, ашиглалтыг шалгахад дараахь зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- ЭМЯ-наас худалдан авах ажиллагааг зохион байгуулж явуулсан Борнуур сумын 2012-2013 онд барьж дуусган ашиглалтанд оруулах байсан ЭМТ-ийн барилга 2013 оны жилийн эцсийн тайланд дуусаагүй барилгаар үнийн зөрүүтэй бүртгэгдсэн байна.

- Аймгийн Нэгдсэн эмнэлгийн машин тоног төхөөрөмжийн бүртгэлд 2006 онд БНСУ-ын буцалтгүй тусламжаар ирсэн HYUNDAI маркын 18.2 сая төгрөгийн өртөгтэй автомашин, уг машин дотор дагалдаж ирсэн рентгений тоног төхөөрөмж 20.4 сая төгрөг, нийт 38.6 сая төгрөгийн хөрөнгийг ашиглах боломжгүйн улмаас БНСУ-ын Монгол улс дахь харьяа байгууллага 1 сарын дараа буцаан татаж авсан байтал аймгийн нэгдсэн эмнэлгийн дансанд бүртгэлтэй байна.

- 2009 онд Солонгос улсын хандиваар орж ирсэн тус бүр нь 1,6 сая төгрөгийн өртөгтэй эмэгтэйчүүдийн үзлэгийн зориулалттай 2 ширхэг багаж хэрэгсэл ирсэн өдрөөсөө нэг ч удаа ашиглагдаагүй

- 2012 онд ашиглалтанд орсон 39.2 сая төгрөгийн өртөгтэй өндөр даралтат уураар ариутгагч бойлер, 37.8 сая төгрөгийн өртөгтэй 250л автомат автоклавууд нь 1 жил хэвийн ажиллагаатай ашиглагдаж байгаад 2 дахь жилээсээ усны хатуулгаас үүдэлтэй гэмтлүүд илэрч түр хугацаагаар зогсож 1 жилийн хугацаанд нийт 3.5 сая төгрөгний засвар үйлчилгээ хийгдсэн.

- 2011 онд ашиглалтанд орсон 12.3 сая төгрөгийн өртөгтэй биохимийн анализатор нэг удаагийн оношлуур нь 36.0 мянган төгрөгийн үнэтэй, нэг оношлуураар нэг хүнд нэг удаагийн шинжилгээ хийдэг учраас уг тоног төхөөрөмж өндөр үнэтэй оношлууртай гэдэг шалтгаанаар ашиглагдахгүй байна



ДҮГНЭЛТ

1. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэргүүлэх чиглэл болгож орчин үеийн болон уламжлалт анагаах ухааны дэвшилтэд аргад тулгуурлан хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэхэд эрүүл мэндийн байгууллагын бие даасан нээлттэй, өмчийн олон хэлбэрт тулгуурлан ажиллаж, эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтийг ханган ажиллаж байна.

2. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар Эрүүл мэндийн тухай хуулинд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэн Төрөөс Эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

3. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын шалгуур үзүүлэлт өнгөрсөн оноос сайжирч, чанарын хяналтыг эрүүл мэндийн байгууллагын дотоод хяналтын багаар болон Мэргэжлийн хяналтын газрын шалгалтаар хийж илэрсэн алдаа, зөрчлийг арилгуулан, арга зүйн зөвлөмж өгч хэрэгжүүлэн ажиллаж байна.

4. Эрүүл мэндийн сайд аймгийн Засаг даргын хооронд байгуулсан Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөл хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээгээ дүгнээгүй, аймгийн засаг дарга Эрүүл мэндийн газрын даргатай үр дүнгийн гэрээ байгуулаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 65.1.3, 40.3 дахь заалтыг зөрчсөн байна.

5. Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд заасан “Нийгмийн эрүүл мэндийн төв” байгуулах гэсэн зорилт хэрэгжээгүй байна.

6. Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагч болон аймгийн засаг дарга хооронд байгуулсан гэрээнд тусгасан хөрөнгө оруулалт, санхүүжилтээр хийгдэх худалдан авах ажиллагаа хуулийн дагуу явагдаагүй байна.

7. ЭМЯ-наас хийгдсэн хөрөнгө оруулалтын ажил хугацаандаа хийгдэхгүй, ямар ч хяналтгүй, нийлүүлсэн тоног төхөөрөмж нь шаардлага хангахгүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэнд үндэслэн:

Гүйцэтгэлийн аудитын дүн дүгнэлтэнд үндэслэн нарт зөвлөх нь:

1.Эрүүл мэндийн сайд аймгийн Засаг даргын хооронд байгуулсан Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөл хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээгээ дүгнээгүй, аймгийн засаг дарга Эрүүл мэндийн газрын даргатай үр дүнгийн гэрээ байгуулаагүй байсан зөрчил дутагдлыг давтан гаргуулахгүй байж, холбогдох буруутай албан тушаалтнуудад хариуцлага тооцон ажиллах.

2.Эрүүл мэндийн байгууллагуудын төсвийн төлөвлөлт хуваарилалтыг зохицуулан мөрдөж байгаа тушаал, дүрэм, аргачлал, журмыг өнөөгийн нөхцөлд тохируулан өөрчлөх.

3.Төсөв мөнгөний хүрэлцээгүй байдлаас болж эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдээр эм, тариа авахуулах тохиолдол зарим үед гардаг явдлыг арилгах

4.Эм, эмнэлгийн хэрэгсэл болон бусад бараа бүтээгдэхүүний худалдан авалтыг ТБОНӨХБАҮХАТухай хуулийн дагуу зохион байгуулах

5.Аймгийн Нэгдсэн эмнэлэгт ашиглалтгүй байгаа тоног төхөөрөмжийн асуудлыг шийдвэрлэх

Холбогдох байгууллагын санал

Холбогдох байгууллагын санал

Хавсралт 1.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫН ҮЗҮҮЛЭЛТ

№	Шалгуур үзүүлэлт	Өмнөх он	Тайлант оны гүйцэтгэл	Өөрчлөлт (+ -)	Тайлбар
1.	Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгэнд хамрагдсан 40 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь	34.41	36.38	+ 1.97	
2.	Чихрийн шижин хэв шинж 2 өвчний эрт илрүүлгэнд хамрагдсан 40 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь	27.50	30.94	+ 3.44	
3.	Хөхний өмөнгийн эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан 30 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь	32.37	27.70	- 4.67	
4.	Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлгэнд хамрагдсан 30 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь	71.30	53.40	- 17.9	
5.	Өрхийн, сумын эрүүл мэндийн төвийн нийт үзлэгт гэрийн эргэлтийн эзлэх хувь	11.22	8.03	- 3.19	
6.	Жирэмсний эхний 3 сард хяналтанд орсон эхийн эзлэх хувь	87.88	86.85	- 1.03	
7.	2 настай хүүхдийн дархлаажуулалтын бүрэн хамрагдалтын эзлэх хувь	98.64	98.49	- 0.15	
8.	Дутуу төрөлтийн түвшин (37 долоо хоногоос бага) 1000 амьд төрөлтөд		1.67		
9.	Амьгүй төрөлтийн түвшин (1000 төрөлтөд)	3.86	3.53	- 0.33	
10.	Нийт төрөлтөөс кесар хагалгаагаар шийдвэрлэсэн төрөлтийн хувь	16.01	19.44	+ 3.43	
11.	Эхийн эндэгдлийн түвшин (100.000 амьд төрөлт тутамд)	96.06	0.00	- 96.06	
12.	2500 грамаас доош жинтэй төрсөн нярайн эзлэх хувь	4.44	3.87	- 0.57	
13.	1500-1800 грамм жинтэй нярайг амьдруулсан хувь		75.0		
14.	Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд)	13.45	12.31	- 1.14	
15.	Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд)	23.06	13.19	- 9.87	
16.	Ходоодны шархлаа өвчний шалтгаант нас баралтын түвшин (0-74 насны 10.000 хүн амд)	0.23	0.23	0.0	
17.	Даралт ихсэх өвчний шалтгаант нас баралтын түвшин (0-74 насны 10.000 хүн амд)	0.46	0.23	- 0.23	
18.	Гуурсан хоолойн багтраа өвчний шалтгаант нас баралтын түвшин (0-44 насны 10.000 хүн амд)	0.00	0.00	0.0	
19.	Мухар олгойн шалтгаант нас баралтын түвшин (0-74 насны 10.000 хүн амд)	0.00	0.00	0.0	
20.	Цөсний чулуу, цөсний үрэвслийн шалтгаант нас баралтын түвшин (0-74 насны 10.000 хүн амд)	0.12	0.00	- 0.12	
21.	Тархинд цус харвалтын нас баралтын түвшин (0-74 насны 10.000 амд)	6.68	4.65	- 2.03	
22.	Зүрхний шигдээсийн нас баралтын түвшин (0-74 насны 10.000 хүн амд)	2.99	1.75	- 1.24	
23.	Тухайн эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэний дараа эсвэл шилжүүлсний дараа 1 сарын дотор нас барсан тохиолдлын хувь (нийт хэвтэн эмчлүүлэгчдийн дотор)		0.15	+ 0.15	
24.	Өр авлагын хэмжээ				

Хавсралт 2.

Төв аймгийн Засаг даргын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг үнэлэх шалгуур үзүүлэлт

Ангилал	Шалгуур үзүүлэлт	2012 оны гүйцэтгэл	2013 оны зорилтот түвшин	2013 оны гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь
Аюулгүй байдлын үзүүлэлт	Эмнэлгийн хоног болоогүй нас баралтын хувь	47.06	20.0-25.0	21.31	100.0
	Задлан шинжилгээний хувь	86.95	80-аас дээш	91.18	100.0
	Үндсэн оношийн зөрүүний жигнэсэн дундаж, хувиар	10.0	10-аас доош	12.90	71.0
	Жирэмсэний хяналтанд байх хугацаандаа 6 буюу түүнээс дээш удаа үзүүлсэн жирэмсэн эмэгтэйчүүдийн үзлэх хувь	88.01	95-100	75.68	80.0
	Ходоодны шархлааны шалтгаант нас баралтын түвшин 10.000 хүн амд	0.22	0.0-1.1	0.33	100.0
Хүртээмжийн үзүүлэлт	10.000 хүн амд ногдох их эмчийн тоо	18.16	20.0	20.59	100.0
	Аймгийн нэгдсэн эмнэлгийн 1 их эмчид ногдох амбулаторын үзлэгийн тоо	4776	2500-аас дээш	4181	100.0
	Хөхний хорт хавдарын эрт илрүүлэлтийн хамралтын хувь	32.37	гүйцэтгэлээр	38.93	38.93
	Умайн хүзүүний хорт хавдарын эрт илрүүлэлтийн хамралтын хувь	65.42	гүйцэтгэлээр	63.97	63.97
	Хорт хавдар оношлогдсоноос хойш 5-аас дээш жил амьдарсан өвчтөний эзлэх хувь	31.26	25-аас доошгүй	29.9	100.0
Үр дүнгийн үзүүлэлт	Нялхасын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд)	19.52	23.0-25.0	13.71	100.0
	5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд)	29.28	25.0-27.0	14.52	100.0
	Эхийн эндэгдлийн түвшин (100.000 амьд төрөлтөд)	177.46	0.0	0.0	100.0
	100.000 хүн амд ногдох сүрьеэгийн нас баралт	2.26	1-1.2	4.57	0.0
	Дархлаажуулалтын хамралтын хувь (1 хүртэлх насны хүүхдийн)	99.04	98-100	99.04	100.0
	10.000 хүн амд ногдох хорт хавдар	11.84	13.5-14.0	15.9	86.43
	10.000 хүн амд ногдох зүрхний шигдээс	3.28	9.5-10.5	1.35	100.0
	10.000 хүн амд ногдох тархины цус харвалт	6.57	10.0-12.0	2.05	100.0
	10.000 хүн амд ногдох тэмбүүгийн тохиолдлын түвшин	12.37	8.0-10.0	12.52	74.8
	10.000 хүн амд ногдох вируст гепатит тохиолдлын түвшин	16.35	10.0-15.0	6.49	100.0

Хавсралт 3.

Эрүүл мэндийн үзүүлэлтүүд сүүлийн 3-н жилээр

№	Үзүүлэлтүүд	2011 он	2012 он	2013 он
1	Эхийн эндэгдэл /100000 амьд төрөлтөнд/	0	177.46	0
2	1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл /амьд төрсөн 1000 хүүхдэд/	27.09	19.52	13.71
3	1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл /амьд төрсөн 1000 хүүхдэд/	5.42	9.76	0.80
4	Стационарт эмчлэгдсэн өвчтөний тоо	15602	15436	15085
5	Ор хоног	130551	125301	122087
6	Бүх нас баралт	439	441	369
7	Эмнэлэгт нас барсан бүгд	73	68	61
8	үүнээс хоног болоогүй нас баралтын хувь	42.46	47.05	21.31
9	Жирэмсний хяналтанд эхний 3 сартай авсан хувь	86.47	87.88	86.91
10	Бүгд үзлэг	266934	256448	247090
11	Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь	39.47	42.58	41.50
12	Түргэн тусламжийн дуудлага бүгд	18217	18823	17917
13	Үүнээс алсын дуудлага	5117	5087	4494
14	Халдварт өвчин бүгд /10000 хүн амд/	110.0	96.94	82.87

ЭМТ-401.7. ЭРҮҮЛ МЭНДИЙН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

№	Эрүүл мэндийн байгууллагын нэрс	Ажиллагчдын тоо-Бүгд	Үүнээс											Тусгай мэргэжлийн мэргэжилтэн бүгд	Үүнээс											Бусад ажилтан
			Удирдах ажилтан	НЭМ-ийн мэргэжилтэн	Статистикч их эмч	Статистикч бага эмч	Мэдээлэл технологийн мэргэжилтэн	Хоол тэжээлийн асуудал хариуцсан мэргэжилтэн	ХШҮнэлгээ хариуцсан мэргэжилтэн	*МХА-ны улсын байцаагч	Их эмч		Эм зүйч		Бусад дээд мэргэжилтэн	Сувилагч	Үүнээс: Арга зүйч	Эх баригч	Багийн бага эмч	Бусад бага эмч	Шүдний техникч	Лаборант	Гэрлийн техникч	Эм найруулагч	Бусад	
											Бүгд	Үүнээс: Эмэгтэй														
1.	Сумын ЭМТөв	599		5		25					60	43	1	34	262	124		25	61	5		18		21	7	212
2.	АНЭмнэлэг	326	3	2	2	1	2	1			79	59	3	15	131	101	2	4		8		12	3	3		87
3.	Өрхийн ЭМТөв	26				1					9	8		3	8	8										5
4.	Хувийн эмнэлэг	20		1							8	4		1	3	2					1				1	6
5.	Эрүүл мэндийн газар	54	1	15	1	2	1	1	1				2	6	8	1				3		1		1	2	16
6.	Рашаан сувилал	164	2			1					23	16		21	24	21				2					1	93
7.	Задгай цагаан	19									6	5		2	3	3										8
8.	Хувийн эмийн сан	25											8	2	9									9		6
9.	Бусад газар	9								5	1	1			3	1						1			1	
Бүгд		1223	6	23	3	30	3	2	1	5	180	131	14	82	449	258	2	27	64	18	1	32	3	34	12	425

Баганы дагуу: 4=(5+6); 7=(8+...+18)

ЭМГ-ын 2013 оны төлөвлөгөө, гүйцэтгэл

	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,198,291,400	1,278,611,192	(80,319,792)	106.7
Үндсэн цалин	361,591,400	371,149,532	9,558,132	102.6
Үр дүнгийн урамшуулал	21,262,200	8,095,487	(13,166,713)	38.1
Эрүүл мэндийн даатгалын хураамж	7,657,100		(7,657,100)	0.0
Шимтгэл	34,456,800	42,092,562	7,635,762	122.2
Гэрэл цахилгаан	7,744,000	2,535,870	(5,208,130)	32.7
Түлш халаалт	67,580,400	61,693,304	(5,887,096)	91.3
Цэвэр бохир ус	4,056,700	14,683,156	10,626,456	361.9
Эм	8,675,700	8,674,800	(900)	100.0
Бичиг хэрэг	11,121,900	12,107,315	985,415	108.9
Тээвэр шатахуун	49,950,000	56,810,500	6,860,500	113.7
Шуудан холбоо	4,701,000	3,424,780	(1,276,220)	72.9
Томилолт	5,668,500	15,065,500	9,397,000	265.8
Ном хэвлэл худалдан авах	150,000	60,000	(90,000)	40.0
ХХХЭрэгсэл	4,125,400	1,693,500	(2,431,900)	41.1
БҮТЭлэгдэх зүйлс	4,125,400	3,477,140	(648,260)	84.3
Нормын хувцас зөөлөн эдлэл	1,143,500	1,142,600	(900)	99.9
Мэдээлэл технологийн үйлчилгээ	9,900,000	8,801,200	(1,098,800)	88.9
Аудит баталгаажуулалт	32,400		(32,400)	0.0
Банк санхүүгийн байгууллага	27,000		(27,000)	0.0
Тээврийн хэрэгслийн даатгал	1,140,000	853,020	(286,980)	74.8
Тээврийн хэрэгслийн оношилогоо	300,000	300,000	-	100.0
Урсгал засвар	857,800	6,620,850	5,763,050	771.8
Хог хаягдал	300,000	120,000	(180,000)	40.0
Дотоод эх үүсвэрээс санхүүжүүлж байгаа	10,260,000	15,355,320	5,095,320	149.7
Тэтгэвэрт гарахад нь олгох 1 удаагийн	437,216,400	437,216,400	-	100.0
Шагнал урамшуулал	1,000,000	6,235,300	5,235,300	623.5
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай	143,247,800	143,247,800	-	100.0
Нэг удаагийн буцалтгүй тусламж		1,016,000	1,016,000	
Урьд оны төсвийн хэмнэлтийн зарцуулалт		5,542,562	5,542,562	
Бусад төсөл арга хэмжээ		36,198,962	36,198,962	
Төвлөрүүлэх шилжүүлэг		10,347,988	10,347,988	
Сургал семинарын зардал		3,490,000	3,490,000	
Төлбөр хураамж жижиг татварууд		559,745	559,745	

АНЭ-ийн 2013 оны төлөвлөгөө, гүйцэтгэл

	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,487,888,900	3,985,789,250	(1,497,900,350)	160.2
ЭМДС-ийн шилжүүлэг	1,454,889,900			
Үндсэн үйл ажиллагааны орлого	55,000,000			
Үндсэн цалин	2,255,214,500	2,395,384,764	140,170,264	106.2
Үр дүнгийн урамшуулал	175,413,400	33,670,285	(141,743,115)	19.2
Унаа хоолны хөнгөлөлт	108,000,000	98,050,000	(9,950,000)	90.8
Шимтгэл	228,476,600	227,751,383	(725,217)	99.7
Эрүүл мэндийн даатгалын хураамж	50,772,600	41,063,030	(9,709,570)	80.9
Гэрэл цахилгаан	37,645,100	29,520,151	(8,124,949)	78.4
Түлш халаалт	377,737,100	386,219,530	8,482,430	102.2
Цэвэр бохир ус	80,411,400	68,929,162	(11,482,238)	85.7
Хоол	122,200,000	122,199,940	(60)	100.0
Эм	419,544,100	413,374,098	(6,170,002)	98.5
Бичиг хэрэг	5,811,600	9,043,230	3,231,630	155.6
Тээвэр шатахуун	84,181,100	79,180,800	(5,000,300)	94.1
Шуудан холбоо	6,597,700	4,818,761	(1,778,939)	73.0
Томилолт	10,502,500	7,532,500	(2,970,000)	71.7
Ном хэвлэл худалдан авах	180,000	185,000	5,000	102.8
Багаж	2,000,000	1,252,040	(747,960)	62.6
БҮТЭлэгдэх зүйлс		49,000	49,000	
Нормын хувцас зөөлөн эдлэл	12,656,000	12,655,720	(280)	100.0
Аудит баталгаажуулалт	300,000	1,120,000	820,000	373.3
Банк санхүүгийн байгууллага	350,100		(350,100)	0.0
Тээврийн хэрэгслийн даатгал	240,000	80,000	(160,000)	33.3
Тээврийн хэрэгслийн оношлогоо	120,000	179,000	59,000	149.2
Урсгал засвар	4,780,000	10,602,610	5,822,610	221.8
Хог хаягдал	12,565,000	12,171,100	(393,900)	96.9
Тээврийн хэрэгслийн татвар	8,000		(8,000)	0.0
Шагнал урамшуулал	2,000,000	2,917,500	917,500	145.9
Нэг удаагийн буцалтгүй тусламж		630,000	630,000	
Төвлөрүүлэх шилжүүлэг		1,820,411	1,820,411	
Төлбөр хураамж жижиг татварууд		25,389,235	25,389,235	
			0	

Хавсралт 7.

Эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээний тусгай зориулалтын
шилжүүлгийн төлөвлөгөө гүйцэтгэл

2013.12.31

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө /ессен дүнгээр/	Гүйцэтгэл /ессен дүнгээр/	Зөрүү	Хувь
	НИЙТ ДҮН	5,596,305.70	5,543,381.52	- 52924.2	99.1
1	Алтанбулаг	200,386.70	200,386.70	0.0	100.0
2	Аргалант	173,437.20	169,929.80	-3507.4	98.0
3	Архуст	168,014.40	164,273.30	-3741.1	97.8
4	Батсүмбэр	272,448.00	269,780.70	-2667.3	99.0
5	Баян	198,758.10	198,758.20	0.1	100.0
6	Баяндэлгэр	166,031.40	162,802.80	-3228.6	98.1
7	Баянжаргалан	180,580.80	175,024.30	-5556.5	96.9
8	Баян-Өнжүүл	189,882.40	189,093.10	-789.3	99.6
9	Баянхангай	181,799.80	181,252.60	-547.2	99.7
10	Баянцагаан	194,601.90	193,218.50	-1383.4	99.3
11	Баянцогт	187,802.20	187,801.90	-0.3	100.0
12	Баянчандмань	221,301.80	220,647.40	-654.4	99.7
13	Борнуур	237,869.10	237,784.50	-84.6	100.0
14	Бүрэн	203,939.00	200,579.80	-3359.2	98.4
15	Дэлгэрхаан	181,112.00	179,319.10	-1792.9	99.0
16	Жаргалант	260,220.10	259,786.70	-433.4	99.8
17	Заамар	285,665.00	285,553.70	-111.3	100.0
18	Лүн	228,248.30	218,440.30	-9808.0	95.7
19	Менгэнморьт	191,242.50	184,399.20	-6843.3	96.4
20	Өндөрширээт	191,107.80	189,962.50	-1145.3	99.4
21	Сэргэлэн	191,710.60	193,671.40	1960.8	101.0
22	Сүмбэр	184,295.50	185,023.40	727.9	100.4
23	Угтаал	198,218.30	198,014.60	-203.7	99.9
24	Цээл	197,962.10	196,251.10	-1711.0	99.1
25	Эрдэнэ	210,404.90	207,633.72	-2771.2	98.7
26	Эрдэнэсант	268,087.70	262,744.10	-5343.6	98.0
27	Ёрхийн эмнэлэг	231,178.10	231,248.10	70.0	100.0

Хавсралт 8.

2013 оны 12 сарын 31-ны байдлаарх өглөг авлагын тайлбар

Төв. ЭМГазар

№	Үзүүлэлт	Дүн	Тайлбар
1.	Авлага	2019.3	Ажилчидтай холбогдсон авлага
2.	Өглөг	7736.3	
1.	Түлш халаалтын тооцоо	6793.0	2012 онд санхүүжилт татагдсан, мөн төсөв бага батлагдаж ирсэн.
2.	Тендерийн эмийн	943.3	2013 оны жилийн эцсээр гүйлгээ хаах үед Баян, Баяндэлгэр сумаас орж ирсэн мөнгө татагдсан.

Төв. Нэгдсэн эмнэлэг

№	Үзүүлэлт	Дүн	Тайлбар
1	Авлага	2355.0	Ажиллагчидтай холбогдсон авлага үүссэн. 2014 онд бүрэн барагдуулж байгаа
2	Өглөг:		
1	Урсгал засвар	690.0	Урсгал засварын зардалд: Сантехникийн гадна болон доторх шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн их болон урсгал засвар үйлчилгээ, цахилгааны гадна болон доторх шугам сүлжээний их болон урсгал засвар үйлчилгээ, халаалтын шугам сүлжээ, халаах хэрэгслийн их болон урсгал засвар үйлчилгээ, цэвэр болон бохирын шугам сүлжээний их болон урсгал засвар үйлчилгээ, барилгын модон хийц болон сайжруулсан хуванцар хийцүүд, эд хогшилын мужааны их болон урсгал засварууд багтдаг. Гэвч төсөвлөсөн санхүүжилт нь хүрэлцдэггүй. Иймд бид төсөвтөө багтаахын тулд гол гол ажлуудаа түүвэрлэн авч ээлж дараалалд оруулан засварладаг. 2013 онд Магадлан итгэмжлэх сунгуулахтай холбогдуулан нилээд засвар үйлчилгээ хийгдсэн тул өр үүсээд байна.
2	НХЗЭдлэл	15949.0	1. Магадлан итгэмжлэх шалгалтаар эмнэлгийн зөөлөн эдлэлийг 100% шинэчлэн сольсон 2. Их цэвэрлэгээний давтамж ихэссэн
3	БҮТЭЗ	3361.0	1. Эд хогшил худалдан авах зардалд багаж хэрэгсэл, тавилга, бага үнэтэй түргэн элэгдэх зүйл-/БҮТЭЗ/ багтдаг. Жил бүрийн төсвийн төсөлд хэрэгцээтэй байгаа багаж хэрэгсэл, тавилга, БҮТЭЗ-ийн зардлыг төсөвлөж хүргүүлдэг ч, байнга дутагдаж, эмнэлгийн үйл ажиллагааг хэвийн явуулахад хүндрэлтэй байдаг. 2. Сүүлийн 3 жил эд хогшилын зардал огт нэмэгдээгүй жилийн 2 сая төгрөгний төсөвтэй, төсөв огт хүрэлцдэггүй. 3. Магадлан итгэмжлэлтэй холбогдуулан тасаг нэгжүүдэд дутагдалтай байгаа хогийн хувин, түмпэн, сав суулгыг авч өгсөн. 4. Төсөвтөө багтаагаад тасгуудын гэрэл, чийдэнг арай хямд өртөгөөр авч өгөхөөр 7 хонолгүй шатчихдаг. Тасаг нэгжүүдийн 80-90% нь гэрэлтүүлэг муу.
	Нийт дүн	20000.0	